СКАЙ ХАЙПЕРМАКЕТ ХХК

emart

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

0.0 Бидний тухай

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ 3
Компанийн танилцуулга 4
Үйл ажиллагааны танилцуулга 8

1.0 Тогтвортой байдлын онцлох үзүүлэлтүүд

1.1 Байгаль орчин 12
1.2 Нийгэм 17
1.3 Засаглал 18

2.0 Тогтвортой байдлын ойлголт

2.1 Тогтвортой байдлын менежмент, стратеги 20
2.2 Оролцогч талуудын харилцаа 21

3.0 Тогтвортой байдлын гүйцэтгэл

3.1 Байгаль орчны менежмент 24
3.2 Нийгмийн хариуцлага 30
3.3 Хариуцлагатай засаглал 54

4.0 Хавсралт

4.1 Гишүүнчлэл болон шагнал 58
4.2 НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилго 60

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

“Скай Хайпермаркет ХХК” нь тогтвортой байдлын тайлангийн анхны дугаарыг олон нийтэд хүргэж байна.

Энэхүү тайланд компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн амлалт, алсын хараа, зорилго, зорилт, хэрэгжүүлсэн ажил, оролцогч талуудын харилцаа, харилцааны арга замуудыг багтаасан болно.

Нээлттэй тайлагнаснаар худалдааны салбарын тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн талаарх байр суурь, зорилго, үйл ажиллагааны нэгдсэн ойлголтыг оролцогч талууддаа өгч, сайн засаглалын ёс зүйн зарчимд тулгуурласан үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагаа, байгаль орчин, нийгмийн эерэг нөлөөллийг үзүүлэх, хамтын үнэ цэнийг бүтээх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд нэг алхам урагшилна гэдэгт итгэж байна.

Тайлангийн хугацаа

Энэ тайланд орсон мэдээлэл нь 2016 оны 7 дугаар сараас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамрах болно.

Тайлагнах зарчим

Энэхүү тайланг “Тайлагналын Олон Улсын Санаачилга” (GRI), НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд” (НҮБ-ын SDGs), зэрэг олон улсын санаачилга, зарчмуудыг удирдамж болгосон бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улсын “Имарт Инк” компанийн тогтвортой байдлын тайланг загвар жишээ болгон ашигласан.

Эрхэм хүндэт үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагч, ханган нийлүүлэгч, харилцагч, хамтран ажиллагсад Та бүхэндээ "Скай Хайпермаркет" ХХК буюу "Имарт Монгол"-ын Тогтвортой байдлын анхны тайланг танилцуулж байгаадаа туйлын баяртай байна.

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн өөрсдийн бизнест тулгуурлан байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй үйл ажиллагааг явуулж оролцогч талуудаа сэтгэл ханамжтай байлгах, тэдэнтэй хамтдаа өсөн дэвжих арга зам, шинэ санааг байнга эрэлхийлсээр ирсэн билээ.

Өнөөдөр дэлхийн байгалийн нөөцөд үр ашиггүй, үрэлгэн байдлаар хандаж зөвхөн эдийн засгийн өсөлтөд анхаарснаас болж бидний ашиглаж байгаа байгалийн эх үүсвэрийн хэрэглээ дэлхийн нөөц чадавхаас хэтэрч байна. Мөн хог хаягдлын хэмжээ шингээж боловсруулах хязгаартаа тулж, улмаар хөрсний бохирдол ихсэх зэрэг нийт уур амьсгалын өөрчлөгдөх аюултай үр дагаврыг дагуулж байна.

Байгаль орчин, нийгмийн сорилтууд бидний ирээдүйг тодорхойлж байгаа энэ үед эерэг өөрчлөлтийг бий болгоход бизнес эрхлэгч бүр чухал үүрэг гүйцэтгэн хариуцлага хүлээж байгаа билээ.

Иймд "Скай Хайпермаркет" ХХК нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан эрхэлж буй бизнес, дотоодын үйл ажиллагааныхаа бүх талбарт байгаль орчин, нийгэм, хариуцлагатай засаглалын тогтолцоог нэвтрүүлэхэд дорвитой алхам хийх зорилгоор 2022 оны 12 дугаар сард Тогтвортой хөгжлийн албыг байгууллаа.

Түүнчлэн бид ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээг хангах нөөц бололцоог алдагдуулалгүйгээр эх дэлхийн экосистемийг хамгаалсан, байгалийн биологийн даацыг хэвээр хадгалахад дэмжлэг үзүүлдэг эдийн засаг, экологи, нийгэмд чиглэсэн харилцан уялдаатай цогц үйл ажиллагааг оролцогч талуудын хамтын ажиллагаагүйгээр төсөөлөхөд бэрх билээ.

Тиймээс оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийн харилцааг улам идэвхжүүлэх, сэргээн бэхжүүлэх, хамтдаа хөгжих, хөрөнгө оруулалт хийх зэргээр цар хүрээг нь тэлснээр нийгэмд хамтын үнэ цэнийг бий болгож, дэлхийн болон үндэсний хэмжээний тогтвортой хөгжилд чиглэсэн зорилтуудад дорвитой хувь нэмрээ оруулж чадна.

2023 онд манай компани архитектурын өвөрмөц шийдэл, орчин үеийн барилга зураг төслийн дагуу сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий эрчим хүч, дулаан, усны хэмнэлттэй, хэрэглэгч, үйлчлүүлэгч төдийгүй хамтран ажиллагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг хангасан, олон улсын стандартад бүрэн нийцсэн ээлтэй орчин бүхий 4 дүгээр салбар дэлгүүрээ нээснийг энд дурдахад таатай байна.

Шударга хөдөлмөрийн практик, ёс зүйн эх үүсвэрийг мөрдөх амлалтаа бид тууштай баримталж Имартын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүр тогтвортой хөгжилд хүргэх урт хугацааны аялал болон үргэлжилж байгааг хэлэхэд таатай байна.

Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа, тогтвортой байдал хоёр зэрэгцэн орших даян дэлхийн ирээдүйн төлөө бидэнтэй нэгдсэн Та бүхэнд баярлалаа.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний ууган үйлдвэрлэл, үйлчилгээний компаниудын нэг "Алтай Холдинг" группын охин компани болох "Скай Трейдинг" ХХК-ийн 90 хувь, БНСУ-ын "Имарт Инк" компанийн 10 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2014 онд "Оюуны өмчийг ашиглах эрх олгох, сургалт, техникийн туслалцаа үзүүлэх гэрээ" (License, Training and Technical support agreement)-ний дагуу "Скай Хайпермаркет" ХХК нь байгуулагдсан бөгөөд 2016 оны 7 дугаар сард эх орондоо олон улсын худалдааны стандартыг нэвтрүүлэх, нутагшуулахаар Имарт Чингис салбар дэлгүүрээ нээв.

"Имарт Инк" компани хамгийн анхны дэлгүүрээ Солонгосын Чандонг дүүрэгт 1993 онд нээж байсан бол өнөөдөр хэрэглэгчдэд аз жаргалтай, эрүүл амьдралын хэв маягийг бүтээгч Солонгосын №1 дэлгүүр болтлоо өсөн дэвжиж, 2022 оны байдлаар БНСУ-д 136 Имарт дэлгүүр, 21 бөөний төв, 97 Бэлтгэн савлах төв, 3 Онлайн худалдааны түгээлтийн төв, 260 No Brand дэлгүүр, АНУ-д 53, Вьетнамд 2, Монголд 4, Филиппинд 17 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

"Скай Хайпермаркет" ХХК-ийн толгой компани болох "Алтай Холдинг" группын харьяанд:

- "Алтай кашмир" ХХК
- "Чингисхаан цогцолбор" ХХК
- "Скайтел" ХХК
- "Скай трэйдинг" ХХК
- Юнайтедбродкастинг корпорэйшн (СтарHD ТВ)
- Дата кейр компаниуд багтдаг бөгөөд тус тусын салбарт байгаль орчин, нийгэмд ээлтэй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн эх орондоо хамтын үнэ цэнийг бүтээлцэж байна.

“Скай Хайпермаркет” ХХК буюу Имарт нь 1400 гаруй ажилтан, 100 мянга гаруй төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний цоо шинэ хэв маяг, Монголын хамгийн том буюу 1000 орчим автомашины дулаан зогсоол, гэр бүлээрээ хамтдаа ая тухтай худалдан авалт хийх боломж, тоглоомын төв, спорт заал, номын сан, тоног төхөөрөмжийн хамгийн сүүлийн үеийн стандартыг хангасан 4 салбар буюу “Имарт Чингис”, “Имарт Хороолол, “Имарт Хан-уул”, “Имарт Баянгол” дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд үйлчилж байна.

- “Нэг цэгээс бүх хэрэгцээт бараа, үйлчилгээгээ” авах боломжийг бүрдүүлснээр хэрэглэгчдийнхээ үнэт цагийг хэмнэж, гэр бүлтэйгээ хамтдаа цагийг ая тухтай, баяр хөөртэй өнгөрүүлж, үнэ цэнд тулгуурласан ухаалаг худалдан авалт хийхэд туслах,
- Агаарын бохирдол, түүнээс үүсэх нийгмийн стрессийг тодорхой түвшинд бууруулж байгаль орчин, нийгэмдээ тодорхой хувь нэмэр оруулж эерэг нөлөөллийг түгээх,
- Хямд үнийн бодлогын хүрээнд өргөн хэрэглээний 110 барааг улирал, хэрэглээний онцлогтой уялдуулан сонгон авч, зах зээлийн үнээс хямд үнээр худалдаалан хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд бодит хэмнэлт өгөхийг зорин ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Өргөн сонголт хэзээд, хаана ч

ЭРХЭМ ЗОРИЛГО

Сайн чанарын барааг үргэлж хямд үнээр нийлүүлж, үйчлүүлэгчдийг аз жаргалтай байлгах

УРИА ҮГ:

Монгол хүн та 100 наслаг...

ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Ажилтан
- ✓ Үйлчлүүлэгч
- ✓ Хамтрагч байгууллага
- ✓ Эх орон & Нийгэм
- ✓ Хөрөнгө оруулагч

ҮНЭТ ЗҮЙЛС

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧЭЭ ХҮНДЭТГЭНЭ

Үйлчлүүлэгч бол бидний оршин тогтнох үндэс. Имарт үйлчлүүлэгчдэдээ үргэлж сайн чанарын барааг хямд үнээр худалдаалахын тулд компанийн хэлтэс нэгж, ажилтан бүр бүх хүч чадлаа дайчлан ажиллана

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧАА ХҮНДЭТГЭНЭ

Хөрөнгө оруулагч нь Имартын гол түшиг тулгуур юм. Үр ашигтай менежментээр компанийн үнэ цэнийг үргэлж нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ.

АЖИЛТНАА ХҮНДЭТГЭНЭ

Ажилтан бол Имартын үнэ цэнтэй хөрөнгө мөн. Тиймээс Имартад ажиллаж байгаа бүх ажилтныг хүндэтгэж, хөгжин дэвших бүхий л боломжоор хангана.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГАА ХҮНДЭТГЭНЭ

Имарт нь хамтрагч байгууллагатайгаа харилцан итгэлцэл дээр тулгуурлан хөгжин дэвшихийн төлөө хамтран ажиллана.

ЭХ ОРОН, НИЙГМИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ХАРИУЦЛАГАА ХҮНДЭТГЭНЭ

Имарт нь нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг тул хууль дүрмийг чандлан мөрдөж, тогтвортой өсөлтөөр дамжуулан түүний хөгжилд хувь нэмэр оруулж хамтдаа өсөн дэвжихийг эрмэлзэнэ.

• Бизнес хөгжил • БОНЗ-ын хөгжил

2014 онд **“Скай Хайпермаркет” ХХК** байгуулагдав

2016
Анхны Имарт Чингис салбар нээгдэв

- Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд МҮХАҮТ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2016 оны 5-р сард байгуулав[26]
- 2016 оны 5-р сарын 11-нд Улаанбаатар хотноо “Export to Korea” арга хэмжээг зохион байгуулсан[27]

2017-2018
Имарт Хороолол салбар нээгдэв

- Монгол хүн Та 100 наслаг уриатай хөтөлбөр[1]
- 5 өнгө хөтөлбөр[2]
- Спорт олимпизмыг дэмжих төсөл[3]
- Замын Хөдөлгөөн Хүүхэд - Аюулгүйн бүс аян[4]
- Итгэл найдвараа хуваалцъя[5]

2019
Имарт Хан-Уул салбарын барилгын зураг төслийн ажил эхлэв

- Итгэл, найдвараа хуваалцъя[5]
- ОБЕГ-ын аврах тоног төхөөрөмж бэлэглэв[22]
- Байгалиа хайрлая - Мод тарья[6]
- Спорт олимпизмыг дэмжих төсөл[3]
- Өв - соёлоо өвлүүлье[7]
- Боловсролыг дэмжье төсөл[8]
- Хавдартай өвчтөнүүдэд зориулсан “Эмнэлгийн өрөө төсөл”[9]
- Ирээдүй өөд итгэл хайрлая арга хэмжээ[10]
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжье үйл ажиллагаа[11]
- 5 өнгө хөтөлбөр[2]

2020
Имарт Хан-Уул салбар, түгээлтийн төв нээгдэв

- Аз жаргалтай ажилтан-Зуны зуслангийн байр төсөл[12]
- Чин сэтгэлийн тус хандив[13]
- Имартчуудын сэтгэл- Өүжин мэд эмнэлэг хандив[14]
- Замын Хөдөлгөөн Хүүхэд-Аюулгүйн бүс аян[4]

2021
Имарт Online Shopping Mall үйл ажиллагаагаа эхлэв

2022
Имарт Баянгол салбарын барилгын зураг төслийн ажил эхлэв

- Дэм дэмэндээ аян[15]
- Байгалиа хайрлая - Мод тарих төсөл[6]
- Ирээдүйд байгалиа үлдээе - Хүүхдүүдэд мод бэлэглэх үйл ажиллагаа[16]
- Итгэл, найдвараа хуваалцъя[5]
- Замын Хөдөлгөөн Хүүхэд- Аюулгүйн бүс аян[4]

2023
Имарт Баянгол салбар нээгдэв Гидропоникийн төсөл хэрэгжиж эхлэв

- Байгалиа хайрлая - Бичил хүрээлэн[17]
- Ирээдүйд байгалиа үлдээе - Хүүхдүүдэд мод бэлэглэх үйл ажиллагаа[16]
- Итгэл, найдвараа хуваалцъя[5]
- Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах[18]
- Эко тор[19]
- 5 өнгө хөтөлбөр[2]
- UNICEF, NCAV хамтын ажиллагаа эхлүүлэв[20]
- Хүүхдийн өрөө[21]
- Дэвшилтэт технологи нэвтрүүлэлт[23]
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглаж эхлэв[24]
- Хүргэлтийн цахилгаан машин[25]

1. 34, 50-р хуудас
2. 50-р хуудас
3. 55, 56-р хуудас
4. 49-р хуудас
5. 49-р хуудас
6. 29, 30-р хуудас
7. 53-р хуудас
8. 50, 52-р хуудас
9. 52-р хуудас
10. 53-р хуудас
11. 41, 48-р хуудас
12. 45-р хуудас
13. 53-р хуудас
14. 53-р хуудас
15. 49-р хуудас
16. 29-р хуудас
17. 30-р хуудас
18. 27-р хуудас
19. 31-р хуудас
20. 51, 54-р хуудас
21. 51-р хуудас
22. 49-р хуудас
23. 28-р хуудас
24. 25-р хуудас
25. 26-р хуудас
26. 39-р хуудас
27. 39-р хуудас

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

ИМАРТ ЧИНГИС

2016 оны 7 дугаар сард Монгол дахь хамгийн анхны дэлхийн хайпермаркетийн сүлжээ дэлгүүр **Имарт Чингис** салбараа нээв.

Байршил: Баянзүрх дүүрэг

ИМАРТ ХОРООЛОЛ

2017 оны 9 дүгээр сард **Имарт Хороолол буюу** 2 дугаар салбараа нээв.

Байршил: Баянгол дүүрэг

ИМАРТ ХАН-УУЛ

2019 оны 9 дүгээр сард **Имарт Хан-Уул буюу** 3 дугаар салбараа нээв.

Байршил: Хан-Уул дүүрэг

ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

2020 оны 9 дүгээр сард **Имарт Түгээлтийн Төвийг** ашиглалтад оруулав.

Байршил: Хан-Уул дүүрэг

ИМАРТ БАЯНГОЛ

2023 оны 9 дүгээр сард **Имарт Баянгол буюу** 4 дүгээр салбараа нээв.

Байршил: Баянгол дүүрэг

Компанийн нэр	“Скай Хайпермаркет” ХХК
Үйл ажиллагаа	Жижиглэнгийн ба бөөний худалдаа
Төв оффисын байршил	Улаанбаатар хот, БЗД, 3-р хороо, 12-р хороолол, (13381), Токиогийн гудамж 23, Имарт Чингис салбар
Гүйцэтгэх захирал	Л.Жавзмаа
Ажилтны тоо	1400

1.0

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 БАЙГАЛЬ ОРЧИН/ENVIRONMENTAL

Бүтээгдэхүүний тогтвортой байдлын санаачилга / БТБС/

Өнөөгийн бизнесийн байгууллагын зорилго нь зөвхөн ашиг орлого олох бус (1) өөрийн үйл ажиллагаанаас эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө, ул мөрийг тооцсон, (2) тогтвортой байдлын хүчин зүйлсийн тэнцвэрийг хангасан, (3) оролцогч талуудын урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэж байна.

Солонгосын Имарт Инк компани нь Бүтээгдэхүүний Тогтвортой Байдлын Санаачлага (БТБС)-г гаргасан бөгөөд энэ нь бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Имарт стандарт, зарчим, философийг тодорхойлох судалгаа, хөгжүүлэлт юм. Бүтээгдэхүүний тогтвортой байдлын санаачлагын хүрээнд тогтвортой бүтээгдэхүүнийг дараах 4 ангилалд хуваах тус бүрд нь тулгарч буй асуудал, сорилтуудыг шийдвэрлэхийн төлөө тасралтгүй сайжруулалт хийн ажилладаг. Үүнд:

1) Ногоон бүтээгдэхүүн
2) Тогтвортой эх үүсвэр
3) Эрүүл ахуй/аюулгүй байдал
4) Савалгаа

“Скай Хайпермаркет” ХХК нь энэхүү жишгийг даган өөрийн онцлог, хүчин чадалтай уялдуулж оролцогч талуудтайгаа хамтран өөрийн стандарт болгон нэвтрүүлж байна.

Байгаль орчны хурдацтай өөрчлөгдөж буй хүчин зүйлүүдээс шалтгаалан бүтээгдэхүүний тогтвортой байдал нь тасралтгүй шинэчлэгдэн хувирч байгаа хэдий ч тогтвортой эх үүсвэрээс эрүүл, аюулгүй байдлыг хангасан бөгөөд байгальд ээлтэй сав, баглаа боодолтой ногоон бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгодоо тууштай байж оролцогч талуудтайгаа урт хугацаанд байгаль орчин, эдийн засаг, нийгэмд хамтын үнэ цэнийг бүтээж, хамтран хөгжих болно.

Ногоон бүтээгдэхүүн

Тогтвортой эх үүсвэр

Эрүүл/Аюулгүй байдал

Савалгаа

НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН

БТБС 1.1.1 НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН

Эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн

Бид энэхүү ногоон бүтээгдэхүүний ангилалдаа ногоон/эко болон органик бүтээгдэхүүнийг хамруулдаг.

Ногоон бүтээгдэхүүн нь бусад ижил төстэй бүтээгдэхүүнтэй харьцуулахад эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар бий болсон бүтээгдэхүүн юм.

Органик бүтээгдэхүүн гэж “мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг” хэлдэг (МУ-ын Хүнсний тухай хуулийн 3.1.5)

Ногоон бүтээгдэхүүний ангиллыг онцлон импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ худалдаалж ногоон хэрэглээг хэвшүүлэх замаар нийгмийн эрүүл мэнд болон байгаль орчинд эерэг хувь нэмэр оруулах чиглэлд чармайн ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ЭХ ҮҮСВЭР

БТБС 1.1.2 ТОГТВОРТОЙ ЭХ ҮҮСВЭР

Бүтээгдэхүүн болон түүхий эдийн баталгаат эх үүсвэр, хариуцлагатай худалдан авалт

2018 онд Монгол Улсын Засгийн газар “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг баталж, малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилт тавин “Малын генетик нөөцийн тухай”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлсэн.

Мах, сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэх хүрээнд малын эрүүл мэндийг сайжруулах, баталгаажуулах, бүртгэлжүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын төслүүдтэй хамтран зохион байгуулсан.

Ингэснээр малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой болсон. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газар “Швейцарын хөгжлийн агентлаг”-ийн санхүүжилтээр “Мал эмнэлгийн гэрчилгээ”-г цахимжуулан, хянах системийг орон даяар нэвтрүүлэх ажлыг Имартын мах, махан бүтээгдэхүүнд анхлан ашиглаж эхэлсэн.

“Мал эмнэлгийн гэрчилгээ”-г цахимжуулсан нь Имартын хэрэглэгч, үйлчлүүлэгчид худалдан авч буй мах, махан бүтээгдэхүүн аль нутгийн гарал үүсэлтэй болох, ямар шат дамжлагаар бэлтгэгдэж, хэрхэн тээвэрлэгдэж Имартын лангуун дээр ирсэн тухай бүх мэдээллийг ил тод байлган, худалдан авалт хийхэд давуу талыг олгох үүргээ биелүүлэхэд дөхөм болсон.

ЭРҮҮЛ/АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БТБС 1.1.3 ЭРҮҮЛ/АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эрүүл/аюулгүй, шим тэжээлтэй хүнс

Аливаа улсын төр засгийн амин чухал бодлого нь хүн амыг чанарын баталгаатай, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлт, ариун цэврийн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хангах явдал байдаг билээ.

“Скай Хайпермаркет” ХХК-ийн хувьд эрүүл мэнд, аюулгүй байдал гэдэг нь хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлт, зан төлөвт суурилсан тогтвортой байдлын илэрхийлэл төдийгүй эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх тэргүүлэх стандарт юм. Иймээс ч бид эрхэм зорилгоо “Сайн чанарын барааг үргэлж хямд үнээр нийлүүлж, үйчлүүлэгчдийг аз жаргалтай байлгах” хэмээн тунхагласан.

Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн төдийгүй олон улсын стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг MNS ISO/IEC 17025:2018 стандартаар баталгаажсан өөрийн итгэмжлэгдсэн болон хөндлөнгийн лабораторид чанар, аюулгүй байдлыг шинжлэн баталгаажуулж, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд тасралтгүй нийлүүлэн ажиллаж байна.

САВАЛГАА

БТБС 1.1.4 САВЛАГАА

Сав, баглаа боодол

Бүтээгдэхүүний савлагааны хувьд тээвэрлэлт, борлуулалтын үйл явцтай холбоотой савлагаа, онлайн худалдааны төрөл бүрийн савлагаа, нэг удаагийн хуванцар гэх мэт гээд бүгд багтана.

Үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгч нарын өмнө тулгарч буй томоохон асуудлын нэг нь сав, баглаа боодлын хаягдал юм. Иймээс бид гялгар уутны хэрэглээнээс аль болох зайлсхийж, байгальд ээлтэй сав, баглаа боодолтой бараа бүтээгдэхүүнийг худалдаалахаар зорин ажиллаж байна.

Хэдийгээр бидэнд маш олон сорилтууд тулгарч байгаа боловч сайжруулах боломж байгаа гэж үзэн 3R (reduce-багасгах, reuse-дахин ашиглах, recycle-дахин боловсруулах) зарчимд тулгуурлан хог хаягдлыг багасгах, савлагааг сайжруулах, дахин боловсруулах зорилго тавин үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.2 НИЙГЭМ / SOCIAL

ХАМТДАА ХӨГЖЬЕ /WIN-WIN/

Түнш - харилцагч, ханган нийлүүлэгчид

Бид өнөөдөр өдөр тутмын хэрэгцээт бүтээгдэхүүний худалдаанаас эхлээд бусад хэрэгцээт үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааны цар хүрээнд 1000 гаруй харилцагчдаас бүрдсэн ханган нийлүүлэлтийн сүлжээг Монгол Улсад бий болгосон байна. Түүнчлэн бүтээгдэхүүн нийлүүлэхээс эхлээд эцсийн хэрэглээ цаашлаад устгах хүртэлх үйл ажиллагааны бүхий л үйл явцыг хамарсан тогтвортой байдлын экосистемийг бий болгохыг зорьж байна.

Ажилтнууд

Байгуулагдсан цагаасаа эхлэн манай ажилтнууд компанийн хөгжлийн үндэс суурь нь байсаар ирсэн. Бид хүндлэл, нээлттэй харилцаа, хамтын ажиллагаанд тулгуурласан компанийн соёлыг баримталж, хамтдаа хөгжих ирээдүй рүү урагшлахыг эрмэлздэг.

Олон нийт

Оролцогч талуудтайгаа хамтран нийгмийн үр нөлөөтэй үйл ажиллагааг тууштай зохион байгуулах нь ирээдүй хойч үеийн тогтвортой өсөлт, хөгжил цэцэглэлтийг дэмжих урт хугацааны стратегийн хөрөнгө оруулалт юм.

1.3 ЗАСАГЛАЛ / GOVERNANCE

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ

Б.БАТТҮШИГ ДАРГА | ГИШҮҮН Д.ЗОРИГТ | ГИШҮҮН Б.САМАДИ | ИМАРТ ИНК-ИЙН ГИШҮҮН

Л.ЖАВЗМАА

Гүйцэтгэх захирал

ЖИН НАМ КЮҮ

Хамтын ажиллагаа хариуцсан захирал

Б.БОЛОРМАА

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

З.БААСАНЖАРГАЛ

Борлуулалт, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал

Э.ХАЛИУН

Захиргаа, хүний нөөц эрхэлсэн дэд захирал

Д.МАШБАТ

Гүйцэтгэх захирлын Бизнес эрхэлсэн орлогч, Худалдаа эрхэлсэн дэд захирал

М.ДОРЖЛХАГВА

Хөрөнгө хөгжүүлэлт эрхэлсэн дэд захирал

Т.АЛТАНХУНДАГА

Маркетинг, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал



2.0

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОЙЛГОЛТ

2.1 ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ

"Скай Хайпермаркет" ХХК нь тогтвортой хөгжлийг стратегийн үндсэн чиглэлийн нэг болгон компанийн бүх түвшний үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэйгээр сайн засаглалыг бүрдүүлэн дэлхийн чиг хандлага, уриа санаачилга, НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилгууд"-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Бид 2023 онд Байгаль орчин, Нийгэм, Засаглал /БОНЗ/-ын алсын хараа, тогтвортой хөгжлийн менежментийн үндсэн зорилго, зорилтуудаа тодорхойллоо. Тус тайланд дээрх зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн гол ажлуудыг тусгав.

2.2 ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАА

Бид компанийн бизнесийн болон дотоодод хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааны туршид оролцогч талуудын оролцоог тэгш, хүртээмжтэй, ил тод байдлыг эрхэмлэн, харилцан хүндэтгэлийн зарчмыг баримтлан санал бодлоо нээлттэй солилцон хамтран ажиллаж байна. Оролцогч талуудын БОНЗ-ын ойлголт, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, нэгдсэн зорилгыг бий болгосноор хамтын тогтвортой үйл ажиллагаагаа улам бэхжүүлж, хөгжих болно.

Оролцогч тал	Хамрах гол асуудал	Харилцааны суваг
Үйлчлүүлэгч	Тогтвортой бүтээгдэхүүн, Байгальд ээлтэй, үнэт зүйлд тулгуурласан хэрэглээ, Таатай худалдааны орчин, Сэтгэл ханамж, Хувийн мэдээллийн нууцлал	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, Дэлгүүрийн хэрэглэгчийн үйлчилгээний хэсэг, Имартын албан ёсны нийгмийн сүлжээ (YouTube, Instagram, Emart website, Emart app, TikTok, Twitter)
Ажилтан	Цалин, урамшуулал, Гүйцэтгэлийн шударга үнэлгээ Ажиллах орчин, Хүний хөгжил Ажил амьдралын тэнцвэрт байдал	Сэтгэл ханамжийн судалгаа Сургалт хөгжлийн хөтөлбөрүүд Дотоод мэдээллийн сувгууд Ажилтнуудын дуу хоолой Олон нийтийн үйл ажиллагаа
Нийлүүлэгч	Хамтын ажиллагаа, зэрэгцэн орших Win-win хөгжил Шударга үйл ажиллагаа	Urto.mn website, Худалдан авалтын систем Имартын албан ёсны нийгмийн сүлжээ (YouTube, Instagram, Emart website, Emart app, Цахим хуудас, TikTok, Twitter)
Олон нийт	Бүсийн иргэдэд оруулах хөрөнгө оруулалт Нийгэм, байгаль орчин, дэд бүтцийн түншлэл, Үндэсний болон бүс нутгийн төсөл, хөтөлбөр	Имартын албан ёсны нийгмийн сүлжээ (YouTube, Instagram, Emart website, Emart app, TikTok, Twitter) Дэлгүүр дээрх хэрэглэгчийн үйлчилгээний хэсэг
Санхүүгийн байгууллагууд /олон улсын болон дотоодын банк/	Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, техник технологийн инновацийн хөрөнгө оруулалт хийх зорилгоор санхүүгийн итгэлт түншлэл, баталгаажуулалт	Албан бичиг, цахим шуудан, уулзалт гэх мэт
Төрийн байгууллага	Зөвшөөрөл, шаардлага, хамтын ажиллагаа, төрийн хяналт/шалгалт	Албан бичиг, цахим шуудан, уулзалт гэх мэт
Хувьцаа эзэмшигч/ Хөрөнгө оруулагч	Ил тод засаглал Тогтвортой үнэ цэн Санхүүгийн тогтвортой байдал	Хөрөнгө оруулагчдын хурал, утсан холбоо, цахим шуудан гэх мэт



3.0

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

Дэлхий нийтийн өмнө уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах асуудалд онцгой анхаарал хандуулан дэлхийн дулаарлыг цельсийн 1.5 хэмд хязгаарлах зорилт бүхий Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээрийг тууштай хэрэгжүүлэх үүрэг хариуцлага тулгарч байна.

Энэхүү хэлэлцээрт нэгдэн орсон улс орнууд эдийн засгийн үйл ажиллагаанаас улбаатай хүлэмжийн хийн хэт ялгарлыг бууруулах чиглэлээр тодорхой үүрэг хүлээж байна. Монгол Улс Парисын хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталж, тус хэлэлцээрийн дагуу 2020 онд дэлхийн хүлэмжийн хийг бууруулахад өөрсдийн оруулах хувь нэмэр (Nationally Determined Contribution)-ийг тодорхойлон баталсан.

“Скай Хайпермаркет” ХХК нь бизнесийнхээ үйл ажиллагаанаас үүдэлтэй барилга, тээвэр, хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийг багасгах арга замаар “Монгол Улсын 2030 онд хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах зорилт”-д бодит хувь нэмэр оруулахын тулд өөрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

2023 онд “Скай Хайпермаркет” ХХК нь Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажил эхлүүллээ.



АЛСЫН ХАРАА

Даян дэлхийн Ирээдүйн төлөө Хамтдаа

МАНАЙ ЗОРИЛГО	2023 ОНЫ ЗОРИЛТ
Монгол Улсын 2030 он гэхэд хүлэмжийн хийг 22,7 хувиар бууруулах амлалтад хувь нэмэр оруулах	Уур амьсгал, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах

Хүлэмжийн хийг бууруулах	Тойрог эдийн засгийг бий болгох	Байгаль орчноо хамгаалах
• Эрчим хүч, ус, түлшний хэрэглээг бууруулах	• Хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах • Цаасны хэрэглээг бууруулах	• Ирээдүйд байгалиа үлдээе

3.1.1 ЭРЧИМ ХҮЧ, УС, ДУЛААН, ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ - НОГООН БАРИЛГА

Бид салбар дэлгүүрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, технологийн шийдэлд сайжруулалт хийж эрчим хүч, ус, дулааны хэмнэлттэй ногоон барилгын ангилалд дүйцэхүйц болгох, улмаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахыг зорин ажиллаж байна. Тус зорилтын хүрээнд:

- Монголд анх удаа иж бүрэн хэмжээний барилгын нэгдсэн хяналт удирдлагын Eco structure v3.2 систем (Building Management System)-ийг суурилуулсан Имарт Хан-Уул салбарын барилгыг 2019 онд ашиглалтад оруулсан. Тус систем нь барилгад ашиглагдаж буй 12 төрлийн систем, 360 төхөөрөмжөөс 9000 гаран өгөгдөл хүлээн авч, боловсруулж мэдээлдэг. Ингэснээр нэг цэгээс барилгын бүх дэд бүтцийг хянан удирдаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, систем тоног төхөөрөмжийг хамгийн оновчтой горимоор ажиллуулан, улмаар эрчим хүчний хэрэглээг багасгаж, хэмнэлтийг бий болгосон. Үүний үр дүнд бид цахилгааны хэрэглээнээс ялгарах хүлэмжийн хийг 5.95тнCO_2/жил, дулааны эрчим хүчнээс 645тнCO_2/жил, нийт 651 тн CO_2/жилд хэмнэж чадлаа.
- Түгээлтийн төвийн барилгын цахилгаан, сантехникийн гадна дотор шугам сүлжээг бүрэн шинэчилж, ухаалаг удирдлагатай иж бүрэн ус, дулааны зангилаа, алсаас удирдлагатай гэрэлтүүлгийн систем угсарч суурилуулсан нь эрчим хүчний зарцуулалтыг тодорхой хэмжээнд бууруулж чадсан.
- Түүнчлэн худалдааны болон оффисын зааландаа цахилгаан бага зарцуулдаг, удаан эдэлгээтэй LED гэрэл ашигладаг ба авто зогсоолдоо хөдөлгөөн мэдрэгчтэй LED гэрэл суурилуулснаар цахилгаан зарцуулалтыг 38 хувь бууруулсан.
- Өвлийн улиралд ашигладаг дэлгүүрийн орц, гарцууд дээр цахилгаанаар халдаг халуун хөшиг ашигладаг байсныг усаар халдаг төхөөрөмжөөр шинэчлэн сольж өвлийн улирлын цахилгаан зарцуулалтыг 30 хувь бууруулсан.
- Бүх барилгад мэдрэгчтэй усны цорго суурилуулснаар усны хэрэглээг 30 хувь хүртэл бууруулсан.

2023 онд ашиглалтанд оруулсан Имарт Баянгол салбарын барилгын концепцийг Эрчим хүчний хэмнэлттэй байхаар төлөвлөж, ашиглалтанд оруулсан. Үүнд:

- 550 $м^2$ талбай бүхий хүнхэр метал хийцлэл, 3 давхар Low-E түрхлэгтэй шилэн дээвэртэй.
- Барилгын үндсэн цахилгаан дамжуулах “шин” системээс гадна Монголдоо анхдагч гэрлийн “шин” системтэй.
- Дотор болон гадна заслын материалд CE, CNAS, FSC, OHSAS18001, FDA, ISO14001, REACH, RoHS, PEFC гэх мэт олон улсын стандартуудыг хангасан материалуудыг хэрэглэсэн.
- Бүрэн хэмжээний олон нийтийн барилгын “Building Management System” нэвтрүүлсэн.
- Нарны сэргээгдэх эрчим хүчний үүсвэрийг суурилуулсан.
- Орчин үеийн барилга загварын шийдлийг эрчим хүчний хэмнэлттэй хослуулан дэвшилтэт технологиудыг ашигласнаар жилд 2.9сая кВт.ц дулааны эрчим хүчийг хэмнэж 1002тнCO_2/жил хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан



3.1.1 ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ

Орчин үеийн худалдааны чиг хандлагатай уялдуулан, онлайн худалдааны системийг хөгжүүлж үйлчлүүлэгч, хэрэглэгчдээ аз жаргалтай байлгахын тулд хотын хүн амын нягтаршил ихтэй А, Б бүсэд байрлах салбар дэлгүүрүүдээр дамжуулан онлайн худалдааны хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүллээ. Энэхүү орчин үеийн шинэлэг худалдаа нь хүлэмжийн хийн ялгаруулалт, агаарын бохирдол, замын түгжрэл, түлшний хэрэглээг бууруулахад тодорхой хувь нэмрээ оруулж байгаа гэдэгт итгэж байна.

Сайн чанарын бараа, бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн хэрэглэгчдийн хэрэглээнд нь нэвтрүүлэх зорилгоор бөөний худалдааны багийг бүрдүүлэн орон нутгийн 300 гаруй байгууллага, иргэнтэй хамтран ажиллаж байна.

2023 онд онлайны түгээлтийн үйл ажиллагаандаа цахилгаан автомашиныг нэвтрүүлэн ажиллаж байгаа нь бензин, дизель хөдөлгүүртэй 1 автомашины яндангаас ялгарах нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг 2 дахин бууруулж агаарын бохирдлоос сэргийлж байгаль орчин, олон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй сонголтыг бүрдүүлж чадлаа.

Дугуй унах нь эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ээлтэй амьдралын зөв хэвшил билээ. Бид салбар дэлгүүрүүдийн гадаа дугуйн зогсоолыг байгуулж, дугуйн хэрэглээг дэлгэрүүлж хүн амын эрүүл мэндийг дэмжихийн зэрэгцээ, агаарын бохирдол, замын түгжрэлийг бага ч гэсэн бууруулахад хувь нэмрээ оруулж байна.

- Хурдан шуурхай
- Ширхэг бараг ч хүргэнэ
- Төлбөрийн өргөн сонголттой
- Олон төрлийн барааны сонголттой



3.1.2 ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ

“Скай Хайпермаркет” ХХК нь Имарт салбараа нээсэн цагаасаа эхлэн бизнесийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг багасгах, хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан хаяж хэвшүүлэхийн төлөө тасралтгүй хичээн ажилласаар ирсэн бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Багасгах, ангилах

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж, ангилан ялгаж хэвшихэд хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хялбар байх үүднээс бүх салбар дэлгүүрийнхээ давхар болгонд ангилан ялгаж хаях хогийн сав байршуулсан.

Хаягдал 1 ширхэг хуруу зай 4 м^2 хөрс, 8000 литр ус бохирдуулдаг гэсэн тооцоо байдаг. Өөрөөр хэлбэл нэг ширхэг хуруу зайг энгийн хог хаягдалтай хамт нэг уутанд хаяхад тэр ууттай хог тэр чигтээ аюултай хог хаягдалд тооцогддог тул хуруу зайг зайлшгүй ялгаж хаях нь чухал юм. Иймд хаягдал хуруу зайг зориулалтын цэгт тушааж хэвшүүлэх үүднээс “GP батарей Монгол” компанитай хамтран зориулалтын хайрцгийг салбар дэлгүүр бүрт байрлуулсан.

Дахин ашиглах, боловсруулах

Бид 2018 оноос эхлэн дахивар хог хаягдлыг ангилах зорилгоор цаасан хайрцаг болон гялгар уут шахагч төхөөрөмжийг худалдан авч суурилуулсан.

2019-2023 онд хаягдал цаасан хайрцаг, хуванцар, гялгар уут, модон тавиур, тос зэрэг байгаль орчинд шууд ба шууд бусаар хаягдах хог хаягдлыг хоёр дахь түүхий эдээр ангилан, дахивар хог хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэн ажиллаж байна. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр салбар дэлгүүр тус бүрээс өдөрт гарах хог хаягдлын ачилтыг 1 хувиар бууруулсан.

“Скай Хайпермаркет” ХХК-ийн нэг салбарт жилдээ ойролцоогоор 1-2 мянган тонн хог хаягдал гардаг бөгөөд үүний 12.93 хувийг хүнсний хог хаягдал эзэлдэг. Иймд энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор тасралтгүй судалгаа, эрэл хайгуул хийсний үр дүнд Нийслэлийн Захирагчийн ажлын алба болон Азийн Хөгжлийн Банкны “Хүнсний хаягдлаар бордоо хийх төсөл”-д нэгдэн БОРДОО хийх аргачлалыг хамтран нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Дахин боловсруулсан хог хаягдал	2019-2023	Нэгж
Нийт хог хаягдал	1094	тонн
Цаасан хайрцаг	967	тонн
Гялгар уут	54	тонн
Тос	17	тонн
Хуванцар сав	55	тонн
Модон подоон	0.17	тонн

Хог төвлөрүүлэх цэгт хэрэглэгдэж буй сав, багаж хэрэгсгэл тоног төхөөрөмж



3.1.2 ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ

Бид “Цаасгүй Имарт” болох зорилгынхоо эхлэл болгон дараах ажлуудыг шат дараалан хэрэгжүүлж байна.

Emart app-ийг нэвтрүүлэн гишүүнчлэлийн цаасан анкет төдийгүй гишүүнчлэлийн хуванцар картыг хэрэглээнээс халах. Тус app-ийг ашигласнаар үйлчлүүлэгчид цагаа хэмнэх, оноогоо ашиглах, барааны нэгдсэн мэдээлэл, хямдрал урамшууллын мэдээлэлтэй танилцах, онлайнаар худалдан авалт хийх боломжтой болсон. Цаашид Emart app-ийг улам хөгжүүлж жилд дунджаар 5,2 сая ширхэг хэвлэгдэн гарч байгаа цаасан төлбөрийн баримтыг 50 хувиар бууруулах зорилго тавин ажиллаж байна.

Үүнээс гадна цаасны хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд:

- Оффисын хэрэглээний хэвлэгч машиныг зориулалтын картаар уншдаг хэвлэгч машинаар сольж, буруу өгсөн хэвлэх командыг дунд нь цуцлах боломжтой болгосон.
- Зайлшгүй цаасан дээр хэвлэх шаардлагатай үед цаасныхаа хоёр талд хэвлэх, дахин боловсруулах савнаас цаасыг авч ноорог, тэмдэглэл хийхдээ ашиглаж байна.
- Ажилтнуудын цаасгүй хэрэглээг дэмжсэн мэдээлэл, сургалтыг зохион байгуулж, сурталчлан ажиллаж байна.
- Мөн ажилтны цаг бүртгэлийн программыг нэвтрүүлснээр төрөл бүрийн чөлөөний хүсэлтүүдийг программаар баталж байна.
- Дотоодын харилцагч байгууллагуудтайгаа өдөр тутмын барааны захиалга хийх харилцаа холбоогоо цахим шуудан ашиглан гүйцэтгэж байна.
- Худалдан авалтын төлбөрийн баримттай хамт хэвлэгддэг автомашины зогсоолын хуудсыг халах зорилгоор зогсоолын төлбөрийн киоск байршуулсан.
- Аливаа хэрэглэгчийн судалгааг цаасаар авдаггүй бөгөөд цахим апп ашиглан авч байна.

3.1.3 ИРЭЭДҮЙД БАЙГАЛИА ҮЛДЭЭЕ

Монгол Улс дэлхийн хүлэмжийн хийн 0.1 хувийг ялгаруулдаг ч уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох асуудлыг нэн тэргүүнд авч үзэн, хариу арга хэмжээний нэг болгон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн өрнүүлж, 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулахаар төлөвлөөд байна.

Ингэснээр ойн санг 9.0 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлнэ хэмээн зорилго тавин ажиллаж байна.

"Скай Хайпермаркет" ХХК дээрх санаачилгыг дэмжин компанийн үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах дэвшилтэт, байгальд ээлтэй цэвэр техник, технологи нэвтрүүлэхийн ялдамд уламжлалт мод тарих аянг өргөн цар хүрээтэй зохион байгуулан ажиллаж байна.

Бид 2018 оноос эхлэн жил бүр мод тарих төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Зөвхөн Улаанбаатар хотод төдийгүй хамгийн их тоосжилттой, ногоон байгууламж дутмаг байгаа аймгийн сургууль, цэцэрлэгт мод тарих зорилго дэвшүүлэн Дундговь аймгийн сургууль, цэцэрлэгт 4 жилийн хугацаанд нийт 20,000 ширхэг мод тарьсан. Цаашлаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" санаачилга, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын амлалтад бодит хувь нэмэр оруулахын төлөө илүү өргөн цар хүрээтэйгээр мод тарих, ойн орчныг сайжруулах, цэвэрлэж асрах, улмаар ажилтан, үйлчлүүлэгчид, харилцагчдын шууд болоод шууд бус оролцоог дэмжих төсөл, аян зохион байгуулах судалгааны ажлаа эхлүүлээд байна.

2021 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан уг үйл ажиллагаа маань хязгаарлагдмал байсан ч бид "Өрх бүр нэг мод" аян өрнүүлж Баянзүрх дүүргийн өрхүүдэд мод тарих, арчлах аргыг мэргэжлийн зөвлөхөөр заалган суулгацыг бэлэглэв. Түүнчлэн хүүхдийн баярыг тохиолдуулан ажилтнуудын хүүхэд бүрт нийт 5,000 гаруй модны суулгацыг бэлэглэн байгальд хайртай ирээдүйн ухаалаг иргэдийг бэлтгэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.

2021 онд "Имарт хаана ч тантай хамт" уриатай 7 бүс байгуулах төслийн хүрээнд "Ногоон Имарт Бүс"-ийг бий болгохоор "Хог биш мод тарья" аяныг зохион байгуулж 2000 ширхэг мод тарьсан.



2030 он гэхэд **2,400,000 кг**
Нүүрсхүчлийн хийг Багасгах Зорилго



3.1.3 ИРЭЭДҮЙД БАЙГАЛИА ҮЛДЭЭЕ

2023 онд Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 98 дугаар цэцэрлэгийн хажуу талын 1800м^2 талбайг сэргээн "Бичил цэцэрлэг" байгуулав.

Уг төсөл хэрэгжихээс өмнө энэхүү газар нь хог хаягдлын үлдэгдэл болон зэрлэг өвсөөр хучигдсан талбай байсан ч хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, хөрсний бохирдлыг ариутган сэргээж, өмнө байсан модыг дахин бордож, 500м^2 газарт явган зам тавьж, тухлан суух сандал байрлуулж, 1300м^2 талбайд зүлэгжүүлэлт хийж, 3 метрийн өндөртэй 35 ширхэг гацуурыг шинээр суулгаснаар шинэ ногоон байгууламжийг бий болгосон.

Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 98 дугаар цэцэрлэгийн хажуугийн нийтийн эзэмшлийн талбай
Зүлэгжүүлэлт: 1333м^2
Модны төрөл: 35 ширхэг гацуур
Тохижилт: явган зам 340м^2, хөтөч хавтан 52м^2, бордюр 1020 ширхэг

Имарт Баянгол салбарын гадна талбайн зүлэгжүүлэлт, моджуулалт:
Талбайн хэмжээ: 525м^2
Модны төрөл: 30 ширхэг жодоо, 75 ширхэг гацуур

3.1.3 ИРЭЭДҮЙД БАЙГАЛИА ҮЛДЭЭЕ

“Скай Хайпермаркет” ХХК нь байгальд ээлтэй, түүнийг хайрлаж хамгаалдаг ирээдүйн иргэд, байгаль хамгаалагчдыг бий болгох, Монгол Улсын “Улаан ном”-ын “нэн ховор зүйл” ангилалд орсон, олон улсын хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн бүртгэгдсэн амьтдын нэг болох цоохор ирвэсийн талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Өндөр уулын эзэн” дижитал зургийн уралдааныг зарласан.

Ирвэс нь тухайн газар нутгийн унаган төрхийг хэвээр хадгалахад хамгийн их хувь нэмэр оруулагч, биологийн олон янз байдлын тэнцвэрийг хадгалагч экологийн байгаль хамгаалагч юм.

Уралдаанд түрүүлсэн бүтээл болох бяцхан Гүем-байгаль хамгаалагчийг олон удаа ашиглах боломжтой Имартын эко тор болон аяллын аяган дээр буулган олон нийтэд бэлэглэсэн нь Имартын байгаль хамгаалах санаачлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлын нэгэн хэсэг юм.

Бяцхан Гүем-тэй эко тор, аягыг ашиглаж байгаа хэрэглэгч Та “Байгаль хамгаалагч” юм.

Ирээдүйд байгалиа хамгаалан, үлдээж буй эрхэм Танд баярлалаа.

save the earth





3.2 НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

"Скай Хайпермаркет" нь оролцогч талуудтайгаа хамтран хөгжиж, улс эх орныхоо нийгэм, эдийн засагт хувь нэмэр оруулан хамтын үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорьдог. Энэхүү зорилгынхоо хүрээнд

- Тогтвортой байдлыг түгээе
- Хамтдаа хөгжье/Win-win
- Итгэл найдвараа хуваалцъя зэрэг санаачлагыг хэрэгжүүлэн талуудын хамтын ажиллагааг бэхжүүлж байна.

Оролцогч талуудтайгаа хамтран хөгжихийн зэрэгцээ, тогтвортой байдлын соёлыг түгээж, нийгмийн хөгжилд эерэг хувь нэмэр оруулах, сайн дурын хөтөлбөрүүдийг илүү өргөн цар хүрээтэйгээр санаачлан зохион байгуулж байна.

МАНАЙ ЗОРИЛГО	2023 ОНЫ ЗОРИЛТ
Оролцогч талуудтайгаа хамтран хөгжиж нийгмийн хамтын үнэ цэнийг нэмэгдүүлэх	Оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх

БИДНИЙ ХИЙСЭН АЖИЛ

Тогтвортой байдлыг түгээе	Хамтдаа хөгжье, WIN-WIN	Итгэл найдвараа хуваалцъя
• Тогтвортой орчин • Тогтвортой бүтээгдэхүүн • Тогтвортой хөгжүүлэлт • Тогтвортой чанар • Тогтвортой үйлчилгээ	• Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ • Тогтвортой хамтын ажиллагаа • Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэл • Тогтвортой хүний нөөц • Тогтвортой ХАБЭА	• Тогтвортой иргэд • Тогтвортой оролцоо • Тогтвортой дэмжлэг

3.2.1-1 ТОГТВОРТОЙ ОРЧИН - ЭРХ ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТААТАЙ

“Скай Хайпермаркет” ХХК-ийн Имарт салбар дэлгүүрийн барилгууд нь анхны зураг төслөөсөө эхлээд сайтар төлөвлөж, олон талт байдал, тэгш хүртээмжтэй, таатай орон зайг бүрдүүлж өгсөн.

Манай барилга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан орчин, ариун цэврийн өрөө, нялх хүүхэдтэй эцэг, эхчүүдэд зориулсан хүүхэд хуурайлж, хооллох өрөө, ариун цэврийн өрөө, түр амрах өрөө зэрэг анхан шатны бүхий л хэрэгцээг тав тухтай, хүртээмжтэй байхаар маш нарийн зохион байгуулагдсан бүтэцтэй баригдсан юм. Энэ бүхэн нь манай дэлгүүрүүдээр зочлон үйлчлүүлж байгаа хүн бүрт бидний илэрхийлж байгаа хүндэтгэлийн нэгэн хэлбэр юм.

Түүнчлэн бид дэлгүүртээ сургалт, соёлын лекц, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Бид чадна” төрийн бус байгууллага жил бүр уламжлалт уулзалтаа зохион байгуулж, Имартынхтай адил барилгыг жишиг болгон барьж байхыг уулзалтад оролцогчдод уриалан тунхагладаг уламжлалтай. Бид ийм төрлийн арга хэмжээг тогтмол, уламжлал болгон зохион байгуулснаар олон талт, олон янз байдлын соёлын солилцоо цэцэглэн хөгжих орчныг бүрдүүлдэг гэж үздэг.

3.2.1-2 ТОГТВОРТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Бид оролцогч талуудад бүтээгдэхүүний эхний гарааны цэг буюу түүхий эдийн сонголт, үйлдвэрлэл, хэрэглээ, устгал гэх мэт бүтээгдэхүүний амьдралын мөчлөг дуусах хүртэлх бүхий л хугацаанд тогтвортой байдлыг хангах ойлголт, мэдлэг, боломж, бололцоог ил тод хуваалцах замаар байгаль орчинд ээлтэй байх тогтвортой бүтээгдэхүүний стандартыг бүрдүүлж, ногоон сонголт, зохистой хэрэглээг дэмжигч, хэрэгжүүлэгч байгууллага байхын төлөө ажилладаг.

"Бүтээгдэхүүний тогтвортой байдлын санаачлага Имартын стандарт"

БНСУ-ын "Имарт Инк" компани бүтээгдэхүүний тогтвортой байдлын санаачилгыг гаргасан билээ. "Скай Хайпермаркет" ХХК нь энэхүү санаачилгыг даган хэрэгжүүлснээр цаашид тогтвортой бүтээгдэхүүнд тавигдах шаардлага буюу тогтвортой бүтээгдэхүүний удирдамжийг эх орондоо бий болгохын төлөө чармайн ажиллаж байна.

Байгаль орчин, нийгмийн сайн сайхан байдал, тогтвортой хөгжлийн төлөө манай сонирхогч талууд юуг хамтдаа хийхийг хүсэж байна вэ гэдгийг идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд нээж илрүүлэх, мөн үүний төлөө бид юу хийж чадах вэ гэдгээс бидний тогтвортой бүтээгдэхүүний санаачлага эхэлдэг.

"Ногоон бүтээгдэхүүн"

Солонгосын "Имарт Инк" компанийн ногоон бүтээгдэхүүнүүд БНСУ-ын Засгийн газраас тогтоосон байгальд ээлтэй (ногоон) бүтээгдэхүүний ангилалд багтдаг билээ.

"Ногоон бүтээгдэхүүн" нь байгаль орчинд ээлтэй эсэхийг мэргэжлийн шинжээчдийн хөндлөнгийн үнэлгээгээр дараах гэрчилгээ баталгаа, шошго, зэргээр тогтоодог. Үүнд:

- Эко шошго;
- Нүүрстөрөгч бага шошго;
- Дахин боловсруулсан бүтээгдэхүүний шошго;
- Хүнс, хөдөө аж ахуйн яамны "Органик, пестицидгүй, нүүрстөрөгч бага" гэрчилгээ зэрэг орно.

2008 онд Солонгосын "Имарт Инк" компани нь БНСУ-ын Байгаль орчны яамтай "Нүүрстөрөгчийн хаягдлын системийн тухай" санамж бичигт гарын үсэг зурсан билээ. Тус санамж бичгийн хүрээнд хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс эхлээд түгээх, ашиглах, устгах хүртэлх үйл явцад ялгаруулж буй нүүрстөрөгчийн хийн ялгарлын хэмжээг ил тод мэдээлэх үүрэг хүлээсэн.

Энэхүү ногоон буюу тогтвортой бүтээгдэхүүний татан авалтын тоо хэмжээ, төрлийг жил бүр нэмэгдүүлэн Монголын хэрэглэгчдэдээ хүргэж байна.

"Эрүүл/Аюулгүй бүтээгдэхүүн"

"Скай Хайпермаркет" ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдал, шим тэжээл, чанарт гол анхаарлаа хандуулсаар ирсэн ба "Монгол хүн Та 100 наслаг" уриан дор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдээ худалдаанд гаргахын өмнө өөрсдийн лабораторид шинжлэн хүн амаа эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахын төлөө хичээнгүйлэн ажиллаж байна. Түүнчлэн "No Brand", "Peacock" зэрэг нэрийн брэндүүдийг борлуулахаас гадна "Органик хүнсний тухай хууль"-д заасны дагуу хөндлөнгийн эсвэл хамтын баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулан ХХААХҮЯ-аас хянаж олгосон гэрчилгээтэй органик бүтээгдэхүүнүүдийг "Органик бүтээгдэхүүн"-ий тасагтаа худалдаалж байна.

"Савалгаа"

Эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр бараа бүтээгдэхүүнээс гарах сав, баглаа боодлын хаягдлын асуудал дэлхий дахины хамгийн гол санаа зовоосон асуудлуудын нэг болж байна. Тиймээс бид байгальд ээлтэй сав, баглаа боодолтой бараа бүтээгдэхүүнийг түлхүү борлуулах, дотоодын ханган нийлүүлэгчидтэйгээ хамтран сав, баглаа боодлыг байгальд илүү ээлтэй байлгах санал санаачилга гаргах чиглэл дээр судалгаа хийн ажиллаж байна.

3.2.1-2 ТОГТВОРТОЙ ЭХ ҮҮСВЭР

Шинэ хүнсний бүтээгдэхүүнийг фермерээс шууд хэрэглэгчийн гарт өглөө бүр шинэхнээр нь хүргэх үүднээс Монголын уламжлалт нийлүүлэлтийн олон шат дамжлагат тогтолцоог өөрчилж тариаланч, фермерүүдээс шууд худалдан авалт хийж эхэлснээр зах зээлийн үнийг 20 хүртэлх хувиар бууруулж чадсан. Тэр дундаа ХАА-н гаралтай, Монгол хэрэглэгчдийн өдөр тутам хэрэглэдэг бүтээгдэхүүний категорид EDLP (Everyday low price) хямд үнийн бодлого баримтлан ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хямд үнийн бодлогын хүрээнд өргөн хэрэглээний, өдөр тутам хэрэглэдэг 110 барааг сонгон авч зах зээлийн үнээс хямд үнээр худалдаалан хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд бодит хэмнэлт өгч чаддаг.

Мах: Өнөөгийн монголын махны салбарын өртгийн сүлжээ болох малчин, малын ченж, махны ченж, бөөний төв, жижиглэн худалдааны төв гэх өндөр зардалтай системийг өөрчилж, хагас эрчимжүүлсэн фермертэй хамтран мал эмнэлгийн ерөнхий газрын мөшгөлтийн системийн хяналт дор эрүүл, вакцины үлдэгдэлгүй мах хэрэглэгчдэд хүргэж байна.

Махыг ариун цэврийн шаардлага хангасан орчинд бэлтгэн, зохих горимын дагуу хөргөж сэврээн, нийслэлийн хэрэглэгчдийг өдөр бүр шинэ, эрүүл ахуйн баталгаат чанартай махаар хангасаар байна. Бид ашгийг эрхэмлэх бус урт хугацаандаа зөв бодлого, системтэй үйл ажиллагаа явуулж салбарын цаашдын тогтвортой хөгжил дэвшилд илүүтэй анхаарч байна.

Сүү: Уламжлалт аргаар гар дээрээс худалдаалагддаг байсан түүхий сүүг орчин үеийн стандартад нийцүүлэн нийлүүлэлтийн суваг (cold chain)-г хөгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд зориулалтын танк ашиглан фермээс шууд тээвэрлэн авчирч, автомат төхөөрөмжөөр савлан хэрэглэгчдэд хүргэж байна.

Навчит ногоо: Эх орныхоо хөрсөнд тарьж ургуулсан нарийн ногоог хэрэглэгчдэдээ шууд хүргэж байна.

Цагаан будаа: Амьд будаа буюу бор будаа нь хальсан дотроо чийгшил, шим тэжээлээ алдаагүй шинээрээ байдаг бөгөөд хэрэглэгч хүссэн хэмжээгээрээ цайруулан худалдан авах боломжийг бий болгосноор хүнсэндээ шинэхэн, амттай, эрүүл будааг хэрэглэх боломжийг бүрдүүлж чадсан.

3.2.1-3 ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭЛТ

Монгол орны эрс тэс уур амьсгалын нөлөөнөөс үүдэн бид навчит ногоог 4 улирлын турш тогтмол худалдаалж чаддаггүй билээ. 5-9 дүгээр сард Монгол ногоо, 10-4 дүгээр сард БНСУ, БНХАУ-ын импортын ногоог голлон худалдаалж байна. Иймд хэрэглэгчдийг жилийн турш шинэ ногоогоор хангах зорилго өвөртлөн Имартын хамт олон гидропоник буюу хөрсгүй орчинд усаар тариалах байгальд ээлтэй шинэ үеийн технологи, үйлдвэрлэлийн ажиллагааг нэвтрүүлэх туршилтын ажлыг эхлүүлсэн.

Гидропоник хүлэмжид ургуулсан салат навчийг салбар дэлгүүрүүддээ 2022 оноос 80, 150 граммын савлагаатайгаар нийлүүлж, худалдаалахаас гадна өөрсдийн Deli нэрийн хоолны цехийн түүхий эд материал хэлбэрээр ашиглаж байна. Үрийг Rijk zwaan (Нидерланд), Bejo Mongolia (Нидерланд) компаниудаас худалдан авч тариалалт хийж байна.

Гидропоник технологийн давуу тал:

1. Уламжлалт тариалангийн технологитой харьцуулахад усны хэрэглээ 90 хувь бага;
2. Хүлэмж нь хагас автомат учир ажиллах хүчний зардлыг бууруулахаас гадна, хүнээс хамааралтай алдаа бага;
3. Цаг уураас хамаарахгүй тул уламжлалт тариалалттай харьцуулахад ургацын гарц 20 хувь илүү, болц гүйцэх хугацаа 20 хувиар богино;
4. Хорхой шавж байхгүй, пестицид хэрэглэдэггүй, эрүүл, органик;





Монгол, Солонгос, Япон, Нидерланд улсын мэргэжлийн хүрээлэн болон компаниудаас техникийн болон тариалалтын зөвлөгөө авч, үр дүнтэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн бид худалдан борлуулах шаардлага хангахгүй байгаа ургацыг туулайн үржүүлгийн аж ахуйд тэжээл болгон өгч, үйл ажиллагаанаас ялгарах хог хаягдлыг бууруулж байна.

3.2.1-4 ТОГТВОРТОЙ ЧАНАР

Бараа, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хувьд Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд нийцүүлэхээс гадна дотоод 10 орчим стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чанарын бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг. Бараа, бүтээгдэхүүн хүлээн авах үеийн хяналт, худалдааны явцын хяналт, худалдааны дараах процесст дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлж тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

Энэхүү дотоод хяналтын тогтолцооны хүрээнд MNS ISO/IEC 17025:2018 стандарт буюу “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартад нийцүүлэн 2019 оны 5 сард Химийн шинжилгээний 93 үзүүлэлт, Микробиологийн шинжилгээний 99 үзүүлэлтээр итгэмжлэгдсэн өөрийн Хими, микробиологийн лабораториттой болсон. Үүгээрээ импортын болон харилцагч байгууллагуудын бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна.

2016~2022
Төсөл

Үйл ажиллагаа

ISO итгэмжлэл

Баталгаажилт

Ялгарал/Чадамж

2016.07~2017.10

Лабораторийн төсөл
Анхны хөрөнгө (тавилга, тоног төхөөрөмж)
Тусгай зөвшөөрөл:
- Ажлын байрны дүгнэлт;
- Галын дүгнэлт;
- Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл;
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ;

2017.11~2018

- Үйл ажиллагаа эхлүүлэв

Өөрийн импортын бараа, дэлгүүрт үйлдвэрлэсэн хоол бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулж эхэлсэн.

- Итгэмжлэлийн хүрээгээ тодорхойлж, чадамжаа баталгаажуулж дата, баримт бичгийн сан үүсгэсэн.

2019~2020

- СХГЗ-ын “Үндэсний итгэмжлэлийн төв”-ийн 3 үе шаттай итгэмжлэлийн хяналт, баталгаажуулалтад оров.
- MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангаж, Итгэмжлэлийн гэрчилгээг 2019.05.08 ~ 2021.05.08 хугацаатай авсан.
- Харилцагчийн бараа шинжлэх эрхтэй болсон

2021.08~2022

- 2022 оны байдлаар 6670 SKU бараа шинжлэв.
- MNS ISO/IEC 17025:2018 стандартын давтан баталгаажилтад хамрагдаж, Итгэмжлэлийг 4 жилээр сунгуулав.

3.2.1-5 ТОГТВОРТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ - ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН 5 БАТАЛГАА

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж гэдэг нь үйлчилгээний чанарыг илтгэх чухал шалгуур үзүүлэлтийн нэг бөгөөд худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг түүгээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн өгсөн үнэлгээгээр дүгнэн, цаашид сайжруулах шаардлагатай хүчин зүйлсийг илрүүлэхэд ашигладаг.

1 Хүнсний аюулгүй байдал

ХАДГАЛАЛТЫН ХУГАЦАА ХЭТЭРСЭН БҮТЭЭГДЭХҮҮН СОЛИХ, НӨХӨН ОЛГОХ

Хадгалалтын хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүн худалдахгүй. Хэрэв ажилтны эсвэл харилцагч компанийн, үйлдвэрлэлт, хадгалалтаас үүдэн гарсан алдаа илэрсэн тохиолдолд бүтээгдэхүүнийг солих баталгаа

2 Буруу тооцоолол

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ ШИНЭЧЛЭГДЭЭГҮЙ БУЮУ БУРУУ ТАВИГДАХ

Бид бүтээгдэхүүний үнийг тогтмол шалгадаг. Хэрэв кассанд бичүүлэхэд үнэ зөрүүтэй, давхар бичигдсэн, килограммын барааг буруу кодлосон, таны аваагүй барааг бичсэн байх зэрэг алдаа гарвал буцаалт хийх баталгаа

3 Бараа буцаалт

ТҮРГЭН ШУУРХАЙ МӨНГИЙГ НЬ БУЦААХ, БАРАА БУЦААХ БАТАЛГАА

Бараа, бүтээгдэхүүнийг худалдан авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор буцаах баталгаа
Бараа, бүтээгдэхүүнийг буцаахад тухайн худалдан авсан бараа, бүтээгдэхүүний тооцооны хуудсыг үндэслэх ба бараа, бүтээгдэхүүн нь дахин худалдаалах боломжтой байна

4 Бараа солих

ТҮРГЭН ШУУРХАЙ СОЛИХ БАТАЛГАА

Бараа, бүтээгдэхүүнийг худалдан авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор солих баталгаа. Бараа, бүтээгдэхүүнийг буцаахад тухайн худалдан авсан бараа, бүтээгдэхүүний тооцооны хуудсыг үндэслэх ба бараа, бүтээгдэхүүн нь дахин худалдаалах боломжтой байна

5 Хэрэглэгчийн санал гомдол

3 ӨДРИЙН ДОТОР ХЭРЭГЛЭГЧДЭД ХАРИУ ӨГӨХ БАТАЛГАА

Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах
- Хэрэглэгчийн үйлчилгээний төвийн утас: 7611-0101
- Web: www.e-mart.mn
- Санал хүсэлтийн хайрцаг: Санал хүсэлтийн хуудас бөглөнө.

Санал, гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хэрэглэгчдэд хариу өгч, шийдвэрлэх баталгаа

3.2.2-1 ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГИНЖИН СҮЛЖЭЭ

Имарт нь худалдааны Know-how-г дотоодын бэлтгэн нийлүүлэгч, хувь хүн, албан байгууллагатай хуваалцан "Хамтдаа хөгжих/Win-win" зарчмаар хамтрагч компаниудынхаа зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжин ажилладаг билээ. Энэ зорилгынхоо хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- "Скай Хайпермаркет" ХХК нь МҮХАҮТ-тай Монгол Улсын Засгийн газрын "Экспортыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Үндэсний үйлдвэрлэгч нарт бараа бүтээгдэхүүнээ БНСУ-д экспортлох боломж олгох, худалдан авагч талтай холбох чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр гарын үсэг зурсан.
- 2016 оны 5 дугаар сард "Дотоодын хүч - Export to Korea" Бизнес уулзалтыг МҮХАҮТ болон БНСУ-ын Имарт сүлжээ дэлгүүрийн Худалдан авалтын багийнхантай хамтран үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг БНСУ-д экспортлох боломжийг нээж өгөхийн төлөөх энэхүү арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгч 60 орчим аж ахуйн нэгж оролцон бараа бүтээгдэхүүнээ Солонгосын Имартын худалдан авалтын мэргэжилтнүүдэд танилцуулах бизнес уулзалтыг амжилттай зохион байгуулж экспортод бараа бүтээгдэхүүнээ гаргахад шаардлагатай зөвлөгөөг өгөв. Энэхүү уулзалтаас хойш бодлого, зөвлөмжүүдийг хүргэн хамтран ажилласны үр дүнд 2016 оны 9 дүгээр сард Витафит компанийн ГОЁ жүүс Солонгосын Имартын 160 гаруй салбараар худалдаалагдаж эхэлсэн.
- Бараа бүтээгдэхүүний нэр төрөл, сав баглаа, нийлүүлэлтийн сувгийг хөгжүүлэх чиглэлээр БНСУ, БНХАУ, Узбек, ОХУ зэрэг орнуудад хамтарсан бизнес аялал хийх, гадны мэргэжилтэн урьж зөвлөгөө авах зэргээр ханган нийлүүлэгчидтэйгээ нягт хамтран ажиллаж, үүний үр дүнд интоор, эрдэнэ шиш, гүзээлзгэнэ, пицца, талх нарийн боов, түргэн хоол гэх мэт олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт шинэхнээр нь хямд үнээр хүрэх боломжийг бүрдүүлж чадсан.
- Мөн хүнсний аюулгүй байдал болон тээвэр логистикийн аюулгүй байдалд хяналт хийгдсэнээр түншлэгчдийн хоорондох хамтын ажиллагааг тасралтгүй сайжруулж эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүний нэгэн жишээ нь, "Худалдаа хөгжлийн банк"-тай хийсэн Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Праймван" ХХК нь том оврын хөлдөөгчтэй машин худалдан авснаар тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломжийг бий болгосон.

- Солонгосын Имартын нэрийн “No Brand”, “Loving Home”, “Daiz”, “Electro-man” зэрэг брэндүүдийн бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулахаас гадна зөвхөн Монгол хэрэглэгчдийн зан төлөв, амьдралын хэв маягт тохирсон “Bella Casa”, “Home-Pro”, “UniQ”, “Veloce Moda” зэрэг бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлэн хэрэглэгчдийн хэрэгцээг ханган ажиллаж байна.
- ТҮМНИЙ ҮНЭ (хамгийн хямд үнэ): Амт, чанартай, хамгийн хямд үнэтэй тахианы далавчийг “Баялаг тахиа” ХХК-тай хамтран Түмний үнэ нэртэйгээр гаргасан. Уг төслийн үр дүнд бэлтгэн нийлүүлэгчийн борлуулах тоо хэмжээ, ашиг өсөхийн зэрэгцээ чанарын баталгаатай тахианы махыг хамгийн хямд үнээр Имартын салбар дэлгүүрүүдээс худалдан авах боломжийг хэрэглэгч, үйлчлүүлэгч нартаа бий болгож байна.
- MAP савлагаатай Meat garden төсөл: “Алтан элч” ХХК нь хоол үйлдвэрлэлийн томоохон бэлтгэн нийлүүлэгч бөгөөд үйл ажиллагааг нь улам өргөжүүлэн “Meat garden” төслийг “Скай Хайпермаркет” ХХК-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд хэрэглэгчдэд 14 хоногийн хугацаанд шинэлэг чанараа алдахгүй MAP савлагаатай махыг санал болгож байна.

- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгынхоо хүрээнд Байгальд ээлтэй сав, баглаа боодолтой харилцагч нарын бараа бүтээгдэхүүнийг шууд бэлтгэн нийлүүлэгчээр бүртгэн авч, бараа бүтээгдэхүүнээ Имартын салбар дэлгүүрүүдээр худалдаалах боломжийг олгодог.

Бэлтгэн нийлүүлэгч, импортлогч нартай хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн зөвлөх хөтөлбөр, борлуулалтыг дэмжих хөтөлбөр, брэндинг хийх нээлттэй өдөрлөгийг олон нийтэд тэгш хүртээмжтэй зохион байгуулж оролцогч талуудад бодит хувь нэмэр оруулсаар байна.

3.2.2-2 ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй эх бэлтгэл, дизайн, хэвлэлийн 20 жилийн түүхтэй Пластик Дизайн буюу “Дөл хангай” ХХК-тай хамтран ажилласнаар тус салбарын хөгжилд олон улсын жишгийг нэвтрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсан нь тогтвортой хамтын ажиллагааны сайн жишээний нэг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Имарт Чингис, Имарт Хан-Уул салбарууд дээр үйл ажиллагаа явуулж буй түлхүүр олшруулах үйлчилгээ үзүүлдэг иргэддээ түрээсийн хамгийн доод үнээр гэрээ хийн хамтран ажиллаж байгаа бөгөөд анх гэрээ хийснээс хойш өнөөдөр тухайн иргэд маань үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тоног төхөөрөмжийн шинэчлэл хийн ажиллаж байна.

“Скай Хайпермаркет” ХХК нь хамтын ажиллагааг илүү далайцтай хөгжүүлэх зорилгоор “Өртөө систем”-ийг нэвтрүүлсэн. Өртөө систем нь харилцагчидтайгаа цаг тухайд нь шуурхай мэдээлэл солилцох, санал хүсэлт хүлээн авах систем бөгөөд дараах давуу талыг оролцогч талуудад бий болгодог. Үүнд:



- **Төлбөр тооцоо**
  Нийлүүлэгч нь биеэр ирж тооцоо хийдэг уламжлалт аргыг халж онлайнаар тооцоо нийлж цаг, зардал хэмнэнэ

- **Захиалга**
  Борлуулалгчаас нийлүүлэгчид өгөх барааны захиалгыг онлайнаар илгээхээс гадна гар утсанд цаг алдахгүй мэдэгдэл ирнэ

- **Бараа бүртгэл**
  Шинэ барааны мэдээлэл, үнийн өөрчлөлт, урамшууллын мэдээлэл зэргийг мэдээллийн алдаагүй, хяналттай, шуурхай бүртгэнэ

- **Тайлан**
  Бизнест зориулагдсан борлуулалт болон нөөцийн тайлан гаргана. Өөрийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын мэдээллийг өдрөөр, сараар болон цагаар гэх зэргээр цаг алдалгүй авснаар хяналт хийх, шийдвэр гаргахад тусална

3.2.2-3 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ

“ХӨХ ШОШГО” ХӨТӨЛБӨР:

“Скай Хайпермаркет” ХХК нь 2020 оноос “Хөх шошго” хөтөлбөр хэрэгжүүлэн үйлчлүүлэгч нартаа Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг ялган таниулж, хөх өнгийн үнийн шошго гарган дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжин ажилласан нь нийгэмд үлгэр дуурайлал үзүүлж, хэрэглэгчдийн талархлыг хүлээсэн томоохон ажил болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү хөтөлбөр нь дотоодын баялаг бүтээгдэх дэмжих үүднээс тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ялган таниулах, сурталчилах зорилготой билээ. Хэрэглэгчид Имартын салбар дэлгүүрүүдээр үйлчлүүлэхдээ Монголдоо үйлдвэрлэгдсэн 2500 аж ахуйн нэгжийн 6500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдааны лангуун дээр өрөөтэй байгаа олон нэр төрлийн импортын бүтээгдэхүүн дундаас “Хөх шошго”-ын тусламжтайгаар хялбар сонголт хийх боломжтой юм.

Аливаа улс орны хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь үндэсний үйлдвэрлэл байдаг. Үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахыг уриалж буй Имартын хамт олонд үйлдвэрлэгчид талархалтай хандаж байгаагаа илэрхийлсээр байна.

3.2.2-4 ТОГТВОРТОЙ, ЭРХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

Хүний эрхийн бодлого

"Скай Хайпермаркет" ХХК нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна. Бид ажилтнуудынхаа ажиллах орчин, ажлын цаг, хөнгөлөлт, тэтгэмж зэргийг тогтмол сайжруулсаар байна.

Ажилтны эрхийг хамгаалах ажлын хүрээнд

Манай компанид ажилтны эрхийг хамгаалах Хүний нөөц, хөгжлийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Үйл ажиллагааны дотоод аудитын хэлтэс үйл ажиллагаагаа явуулж, хамтран ажилладаг бөгөөд ажилтан аз жаргалтай, тайван, үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэх нөхцлийг бий болгохыг эрмэлздэг. Түүнчлэн 2022 оноос эхлэн бид ажлын байран дахь бэлгийн дарамт, аливаа төрлийн хүчирхийлэл үйлдэх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулж байна.

Санал гомдлын асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд

"Ажилтны дуу хоолойг сонсох журам"-ыг боловсруулан ажилтнаас санал хүсэлтийн хайрцгаар, гар утасны апп-аар, утсаар, амаар, бичгээр гэх мэт аль ч хэлбэрээр санал хүсэлтээ ирүүлэх боломж, сувгийг нээлттэй ажиллуулж байна. Санал, гомдлыг хүлээн авсан даруйдаа холбогдох ажилтан 3 хоногийн дотор үр дүн, авах арга хэмжээний талаар санал, гомдол гаргасан ажилтанд хариу өгдөг.

Хөдөлмөрийн гэрээ

Хөдөлмөрийн хуулийн дагуу ажилтны туршилтын хугацаа дуусмагц байнгын ажлын байранд хугацаагүй гэрээ байгуулж, туршилтын хугацаанд цалин хөлсийг ижил албан тушаалын үндсэн ажилтантай ижил дүнгээр олгож байна. "Хөдөлмөрийн маргаан таслах комисс" томилогдон ажиллаж, гишүүдийн 50 хувь нь бүх ажилтны саналын үндсэн дээр сонгогдсон ажилтнууд байдаг.

Хүний эрхийн боловсрол, сургалт

Нийт ажилтанд нээлттэй байдлаар онлайн сургалтын программд "ажлын байран дахь бэлгийн дарамт, зүй бус харилцаанаас урьдчилан сэргийлэх" сургалтыг байршуулсан.

Уян хатан цагийн систем

Ажилтан өглөө 7:00~10:00 цагийн хооронд ажил эхлэх цагаа сонгон ажиллах боломжтой. Мөн амралтын өдөр ирж ажилласан бол өөр нэг ажлын өдөр нөхөн амрах зохицуулалтыг бий болгосон.

Ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах

Манай нийт ажилтны 70 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлдэг тул бид эмэгтэй ажилтнуудаа дэмжих зорилгоор олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, "Хүүхэд харах өрөө"-ний төсөл, гэртээ хүүхдээ харж буй ажилтнууддаа богиносгосон цагаар ажиллах боломж, "Цалинтай ээж" хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж байна. Мөн нийт ажилтандаа зориулж гэр бүлээрээ цэвэр агаарт амрах "Ажилтны зуслан" барьж байгуулсан.

Сонгон шалгаруулалт

Бид ажил горилогчдоо нас хүйс, шашин шүтлэг, итгэл үнэмшил, намын харьяалал үл харгалзан, нээлттэй сонгон шалгаруулдаг.

Жендерийн эрх тэгш байдал:
Манай компанийн нийт ажилтны 67.4 хувь нь эмэгтэй ажилтан, 32.6 хувь нь эрэгтэй ажилтан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах:
Ажил горилогч бүрт тэгш, хүртээмжтэй боломжийг олгох зорилгынхоо хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нээлттэй сонгон шалгаруулж, тохирох ажлын байранд ажиллуулдаг. Цаашид бид ажлын байранд тохируулан ажилд авахаас гадна Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах ажлын байрыг бий болгохыг зорьж байна.

Өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг ажиллуулах:
Өндөр насны тэтгэвэртээ гарсан ажилтнуудыг шинээр болон үргэлжлүүлэн ажиллах боломжийг олгодог.

3.2.2-4 ТОГТВОРТОЙ ЧАДАВХИЖУУЛАЛТ

	Багц-1 Дасан зохицуулах хөтөлбөр	Багц-2 Ур чадварын моделийн дагуух хөтөлбөр	Багц-3 Карьер хөгжүүлэх хөтөлбөр	Багц-4 Захиалгат сургалтын хөтөлбөр	Багц-5 Байгууллага хөгжүүлэлтийн хөтөлбөр
Зорилго	Имартын хүсэмжит ажилтны ойлголтыг өгөх, Компанидаа богино хугацаанд дасгах	Албан тушаал бүрт шаардах ур чадварыг олгох	Дараагийн албан тушаалд дэвшихэд бэлтгэх	Нарийн мэргэжлийн ур чадвар олгох	Байгууллагын эерэг соёлыг бэхжүүлэх, ажилтны гэр бүл, эрүүл мэнд, санхүүгийн боловсролд мэдлэг нэмэх
Үр дүн	Богино хугацаанд дасан зохицож, ажилтны тогтворжилт нэмэгдэнэ	Тухайн албан тушаалд шаардах ур чадварыг эзэмшинэ	Шаардлага хангахуйц ажилтныг бэлтгэсэн байна	Нарийн мэргэжлийн ур чадвартай ажилтнууд бэлтгэгдсэн байна	Сэтгэл хангалуун, эрүүл ажилтны тоог нэмэгдүүлэх

2023 оны байдлаар давхардсан тоогоор 10,245 ажилтан дээрх сургалтуудад хамрагдаж, амжилттай төгсөөд байгаа бөгөөд 1 ажилтан жилд дунджаар 5.2 цагийн сургалтад хамрагдсан.

	2020	2021	2022	2023
Ажилтны сургалтын бүртгэл **Ажилтны нийт сургалтын цаг (нэгж: цаг)**	61,831	64,497	47,312	26,801
Эрэгтэй	27,823	25,798	21,290	13,668
Эмэгтэй	34,007	38,698	26,021	13,133
Ажилтны жилийн дундаж сургалтын цаг (нэгж: цаг)	4,6	6,4	4,6	7,6
Эрэгтэй	2,07	2,56	2,07	3,8
Эмэгтэй	2,53	3,84	2,53	3,8

3.2.2-4 АЗ ЖАРГАЛТАЙ АЖИЛТАН

Ажилтнуудын эрүүл мэндийн хөтөлбөр

Биеийн эрүүл мэнд

"Скай Хайпермаркет" ХХК нь ажилтнуудынхаа биеийн эрүүл мэндийг анхаарч урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалдаг.

Үзлэг шинжилгээгээр хагалгаанд орох заалттай хүнд хэлбэрийн өвчтэй 7 ажилтны өвчнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадсан.

Түүнчлэн манай ажилтнуудад нурууны суултын зовуурь нийтлэг тохиолдож буйг илрүүлж, ажлын байран дээр хийх боломжтой 15 минутын дасгалын видео бичлэг хийлгэн өдөр бүр 15:00 цагаас дагаж хийж хэвшүүлсэн.

Салбар бүрт ажилтнуудын цайны газар ажиллуулан өдөрт авах илчлэгийг нь тогтмол цагт эрүүл, халуун хоолоор нь дамжуулан өгч байна.

2020 оноос ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулж байгаа бөгөөд даатгалын хураамжийн дүнг ажилтны ажилласан жилээс шалтгаалан 5-100 хүртэл хувиар хөнгөлж байна.

7 хоногт 1 удаа спорт заал авах, сайн дурын "Hyper hiking", "Bicycle" клубүүдэд нэгдэх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл хөдөлдөөнд уриалдаг.

Санхүүгийн эрүүл мэнд

Ажилтны санхүүгийн нөхцөл байдлыг тогтвортой байлгах үүднээс тохиолдож болох уй гашуу, баяр ёслолд хамт олноос мөнгө хураахгүйгээр байгууллагаас мөнгөн тусламж үзүүлж, цалинтай чөлөө олгодог. 2017 оноос хойш давтагдсан тоогоор нийт 686 ажилтанд 207,348,450 төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусламж олгожээ.

Олон жил тогтвортой ажиллаж байгаа боловч их, дээд сургуулийн төлбөр төлөх боломжгүй ажилтанд боловсролын тэтгэлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Манай ажилтнууд өөрийн салбар дэлгүүрээс худалдан авалт хийхдээ 10-15 хувийн хөнгөлөлт эдэлдэг нь давхар хэмнэлтийг бий болгож байна.

Сэтгэл зүйн эрүүл мэнд

Ажилтныг Имартын гэр бүлд нэгдсэн цагаас эхлэн дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэн, баг хамт олон, удирдлагатайгаа гэр бүлийн гишүүн шиг дотно уур амьсгалыг бий болгох, ажилтны оролцоог нэмэгдүүлэх, ажилтны стрессийг буулгах, хамт олны эерэг хандлагыг бий болгох зэрэг зорилгоор нийт 1400 гаруй ажилтныг хамруулсан дараах олон нийтийн томоохон арга хэмжээг уламжлал болгон тогтмол зохион байгуулдаг: "Цасны баяр", "Урлагийн болон Спортын их наадам", "Зуны зугаалга" гэх мэт.

Салбар бүрт бүх нийтийн хурлыг сард 1 удаа зохион байгуулж, хурлаар шинэ ажилтныг хүлээн авах, тухайн сардаа сайн ажилласан ажилтныг шагнах, төрсөн өдөр нь тохиож буй ажилтанд хамт олноороо мэндчилгээ дэвшүүлэх, ирэх сардаа эрч хүчээр ажиллах урам зориг өгдөг.

Жил бүр ойн баярын хурал хийж тогтвортой ажилласан ажилтнуудаа ажилласан жилээс хамаарч Имартын лого бүхий дурсгалын зүйл хадгалуулдаг. Үүнээс 5 жил ажилласан ажилтанд Монгол уламжлал, өв соёлоо түгээн дэлгэрүүлж, үр хойчдоо өвлүүлэн үлдээх санаачилга болгон Мастер морин хуур бэлэглэдэг уламжлалыг бий болгож ажилтнуудын ажилласан жилийн үнэ цэнийг өсгөж хамт олны дунд алдаршуулдаг.

Гэр бүлийн эрүүл мэнд

Имартын ажилтан ажил дээр ч, гэртээ ч аз жаргалтай байхад чиглэсэн гэр бүлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилладаг. Үүнд:

- Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор хамтран ажилладаг банканд тусгайлан хүсэлт гарган байгууллагын түлхүүр ажилтан болох 21 ажилтанд ипотекийн зээл хүсэхэд дэмжлэг туслалцаа үзүүлсэн.
- 2021 оноос 12 айлын дуплекс хаус бүхий бүрэн тавилгатай, дэд бүтэц шийдэгдсэн Имартын ажилтнуудад зориулсан зусланг ашиглалтад оруулж нийт ажилтанд ашиглалтын зардлаар буюу маш хямд үнээр, гэр бүлээрээ цэвэр агаарт, 4 улирлын туршид амрах боломжоор ханган ажиллаж байна.

3.2.2-4 ТОГТВОРТОЙ АЖИЛТАН – ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Манай шагнал, урамшууллын бодлого нь тогтвортой ажилтанд түлхүү чиглэдэг бөгөөд улсын болон бусад эрх бүхий байгууллагуудын шагналд тодорхойлохдоо компанидаа бүтээмжтэй, урт удаан хугацаанд ажилласан байдлыг чухалчлан үздэг.

Манай компани үйл ажиллагаагаа нээснээс хойш буюу 2016~2023 онд жилд дунджаар 76 ажилтныг шагнажээ. Нийт 39 ажилтан Вьетнам, Солонгос Улсаас гадна Европ, Араб руу аялах эрхээр шагнагдсан байна.

ШАЛГАРУУЛАЛТЫН ЯВЦ

I шат
Удирдлагын сонголт
Багийн шууд удирдлага шалгуурт тэнцсэн 5 ажилтныг нэр дэвшүүлнэ

II шат
Хамт олны сонголт
Багийн нийт гишүүдийн саналаар 1 ажилтан шалгарна

III шат
Удирдлагын зөвлөл
Нэр дэвшсэн ажилтан тус бүрээр санал хурааж компанийн хэмжээнд шагнагдах ажилтнуудыг тодруулна

Дотоод
- Шилдэг салбар
- Шилдгийн шилдэг ажилтан
- Шилдэг манлайлагч
- Шилдэг ажилтан
- Өсөх ирээдүйтэй ажилтан
- Сарын шилдэг ажилтан
- Гүйцэтгэх захирлын нэрэмжит шагнал

Гадаад
- Ерөнхийлөгчийн шагнал
- Яамдуудын шагнал
- Нийслэлийн ЗДТГ-ын шагнал
- Дүүргүүдийн шагнал
- МҮХАҮТ-н нэрэмжит шагнал
- МЗХ-ны нэрэмжит шагнал

Имартын Шилдэг ажилтанд нэр дэвшигчид дараах шалгуурыг хангасан байна

01 1 жилээс дээш хугацаанд ажилласан байх
02 Ажилласан цаг 90 хувиас дээш байх
03 1 жилийн дотор Сахилгын шийтгэлгүй байх
04 Имартын хүсэмжит ажилтан байх

3.2.2-5 ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН

"Скай Хайпермаркет" ХХК нь Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд дотооддоо хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмуудыг боловсруулан баталж, түүний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ХАБЭА-н хүрээнд хийж гүйцэтгэж буй ажлууд:

- ХАБЭА-н эрсдэлийн үнэлгээг төлөвлөгөөний дагуу хийж, хяналтын арга хэмжээг төлөвлөн, хариу арга хэмжээ авч, сайжруулан ажиллаж байна.
- Ажлын байр бүрээр аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж, өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр хөтлөн, хяналт хийж байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын дотоод хяналтын 3 шатны үзлэгийг хэвшүүлэн ажиллаж байна.
- Ажлын байр, амрах өрөөнд ХАБЭА-н нийт 12 видео хичээлийг байршуулан, аюулгүй ажиллагааны мэдлэг түгээн ажиллаж байна.
- Имартын бүх объектод ХАБЭА-н тэмдэг тэмдэглэгээ, аврах зам гарцын тэмдэглэгээ бүрэн хийгдсэн байна.

ХАБЭА-н сургалтууд

ХАБЭА-н мэдлэг, дадлага олгох сургалтыг жил тутам хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулж нийт ажилтанд мэдлэг, дадлага олгодог. Үүнд:

- ХАБЭА-н мэдлэг олгох 4 төрлийн сургалт;
- Анхан шатны тусламж үзүүлэх сургалт;
- Үйлдвэрлэлийн осол судлан бүртгэх комиссын гишүүдийг чадваржуулах сургалт;
- Удирдах ажилтны ХАБЭА-н мэдлэг олгох сургалт;

ХАБЭА-н нэгдсэн арга хэмжээ

Жил бүрийн 4 болон 10 дугаар сард Дэлхийн ХАБЭА-н өдрийг тохиролдуулан ХАБЭА-н соёл, эерэг хандлагыг бий болгох аяныг зохион байгуулж ирсэн.

2023 онд "Скай Хайпермаркет" ХХК-ийн хэмжээнд Олон улсын ISO 45001 стандартыг нэвтрүүлэх ажил эхлүүлсэн.

3.2.2-5 ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН

"Скай Хайпермаркет" ХХК нь салбар дэлгүүрүүдэд болон түгээлтийн барилгад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр хянуулан Гүйцэтгэх захирлаар батлуулж гамшиг, ослын үед шуурхай хариу арга хэмжээ авч ажиллах бүлгийг томилон бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын Ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу томилогдсон гэрээт Гал түймрийн улсын хяналтын Ахлах байцаагч хяналт шалгалтыг тогтмол хийж, сургалт арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гүйцэтгэж буй ажлууд:

- "Скай Хайпермаркет" ХХК-ийн бүх объектод Гамшгаас хамгаалах төлөвлөгөө;
- Гал унтраах шуурхай төлөвлөгөө;
- Гал унтраах шуурхай карт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ;

Мөн Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд жил бүр нийт ажилтны 40 хувийг хамруулдаг. Дадлага сургуулийн талаарх мэдээ мэдээллийг салбар дэлгүүрийн мэдээллийн дэлгэцээр олон нийт, үйлчлүүлэгчдэд хүргэж ажилладаг.

Имарт болон түрээс, шимтгэлийн ажилтнуудад шилжүүлэлт, гал унтраах дадлага сургуулилтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

2022 онд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит 100 ААН-ийн бэлэн байдлын үзлэгт томилгоот байгууллагын 1250 ажилтан, Гамшгаас хамгаалах 9 алба, 10 мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 35 техник, багаж хэрэгсэлтэйгээр оролцсон сургалт, дадлагад "Скай Хайпермаркет" ХХК оролцож эхний 10 байранд шалгарсан амжилтыг гаргасан.

3.2.3-1 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ –ИТГЭЛ НАЙДВАРАА ХУВААЛЦЪЯ

“Итгэл найдвараа хуваалцъя”

Сар шинийн баярыг тохиолдуулан Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүдэд оршин суудаг, тусалж дэмжих үр хүүхэдгүй ганц бие 112 өндөр настанд 100,000 ширхэг буузыг манай компанийн ажилтнууд өөрсдийн гараар, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд сэтгэлээ шингээн хийж, зориулалтын хөргүүрт хөлдөөж бэлтгэн бэлэглэдэг бөгөөд энэхүү сэтгэлийн аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

“Замын хөдөлгөөн хүүхэд”

Бага насны хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Тээврийн цагдаагийн албатай хамтран автомашины аюулгүйн бүсний тохируулагч бэлэглэх аяныг 2018 оны 3 дугаар сараас эхлэн зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд Ерөнхий боловсролын 51, 84 дүгээр сургуулийн бага ангийн сурагчдад, замын хөдөлгөөнд хүүхдээ аюулгүйн бүсгүйгээр тээвэрлэж буй жолооч нарт, орон нутгийн хүүхдийн элч төлөөлөгч байгууллагуудад нийт 5,000 ширхэг тохируулагч бэлэглэсэн.



“Хүчилтөрөгчийн төхөөрөмж, аврах дэвжээ”

“Скай Хайпермаркет” ХХК нь Солонгосын “Имарт Инк” компанитай хамтран хүнд нөхцөлд иргэдийнхээ амь нас, эд хөрөнгийг галын аюулаас хамгаалахын төлөө амь биеэ золиослон ажилладаг Онцгой байдлын албаны гал сөнөөгч албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд нь хувь нэмэр оруулах зорилгоор БНСУ-ын Гал сөнөөх албанд ашиглагддаг хамгийн сүүлийн үеийн хүчилтөрөгчийн төхөөрөмж, аврах дэвжээ гэх мэт нийт 60 гаруй сая төгрөгийн үнийн дүн бүхий багаж, хэрэгслийг бэлэглэсэн.

“ДЭМ ДЭМЭНДЭЭ” аян

НЗДТГ-аас санаачилсан “Дэм Дэмэндээ” аянд нэгдэж 100,000,000 төгрөгийн үнийн дүнтэй хүнсний багцыг өгөх санал гарган Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нийт 2221 өрхөд хүнсний багц хүлээлгэн өгсөн.

3.2.3-1 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ - ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ

5 өнгө аян: “Өдөрт 5” жимсний сургалт

Манай компани “Монгол хүн Та 100 наслаг” уриан дор хүүхдүүдэд эрүүл, зөв хооллолтыг дэмжих хоол зүйн боловсрол, ухаалаг сонголт, хэрэглээний соёлыг таниулах, хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд 5 өнгийн жимсний сургалтыг 2017 оноос хойш тогтмол зохион байгуулж байна. Тус сургалтаар өнгө өнгийн жимс, ногооны ашиг тусыг таниулан, хэрэглээнд сургахаас гадна тэднийг ирээдүйн ёс зүйтэй үйлчлүүлэгч болоход нь тусалж, худалдан авалтын боловсролын анхан шатны ойлголтыг өгөхийг зорьж байгаа бөгөөд нийт 36 удаагийн сургалтаар 720 хүүхдийг хамруулсан.

3.2.3-2 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ – ТЭГШ ОРОЛЦОО

"Скай Хайпермаркет" ХХК-ийн нийт ажилтны 70 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд ажлын байран дахь жендерийн эрх тэгш байдлыг чухалчлан хангасаар ирсэн билээ. Гүйцэтгэх захирал Л.Жавзмаа тэргүүтэй С түвшний албан тушаалтны 50 хувь, удирдлагын багийн 60 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Гүйцэтгэх захирлын манлайлал, санаачилгын хүрээнд ажилтнуудыг чадавхжуулах Менторшип хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлдэг бөгөөд үүний тод жишээ нь анх бичиг хэргийн ажилтан, худалдааны зөвлөхөөр тус тус ажлын гараагаа эхлүүлж байсан Б.Болормаа, З.Баасанжаргал нар С түвшний захирлын албан тушаал хашиж байна. Түүнчлэн ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг хангах хүрээнд ажлын уян хатан цагийн зохицуулалт, ажлын 4 өдөрт шилжих санаачлага, цалинтай ээж хөтөлбөр, ажилтнуудын хүүхдийн өрөө, хүүхэд хуурайлах өрөө, гэр бүлд ээлтэй бодлогуудыг баримталдаг бөгөөд бусдад үргэлж урианлан түгээж байдаг. Тиймээс ч хүйсийн эрх тэгш байдал болон олон талт, хүртээмжтэй байдлыг дэмжих чиглэлээр манай байгууллагын хүчин чармайлтыг Азийн хөгжлийн банк үнэлэн Захиргаа, хүний нөөц эрхэлсэн Дэд захирал Э.Халиуныг Манила хотод АХБ-ны зохион байгуулсан Жендерийн ээлжит форумд панелистаар урьж, хувийн хэвшлийн туршлага хуваалцах боломж олгов.

Зүүн гар талаас:
Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн Дэд захирал Б.Болормаа, Гүйцэтгэх захирал Л.Жавзмаа, Борлуулалт, үйлчилгээ эрхэлсэн Дэд захирал З.Баасанжаргал, Захиргаа, хүний нөөц эрхэлсэн Дэд захирал Э.Халиун

"Скай Хайпермаркет" ХХК нь 2023 онд Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвтэй Санамж бичиг байгуулж тус төвийн үйлчилгээ, түр хамгаалах байрыг дэмжин ажиллах, даван туулагсдыг ажлын байраар хангах, нийгэмд гэр бүлийн хүчирхийллийн хор хохирол, түүнээс хэрхэн сэргийлэх, хүчирхийлэгчидтэй тэмцэх, даван туулах талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж, сайн сайхан ирээдүйд чиглэсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулахаар тохиролцов.

3.2.3-3 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ – ИТГЭЛ НАЙДВАРАА ХУВААЛЦЪЯ

Боловсрол

Оюутан залуусын тав тухтай орчинд сурч боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Худалдаа Үйлдвэрлэлийн Их сургуулийн 95 жилийн ойг тохиолдуулан "Уншлагын танхим"-ыг тохижуулсан.

"Монголд Та хэрэгтэй" ТББ-ын эзэмшсэн мэргэжлээрээ эргээд нутаг орноо хөгжүүлэх хүсэлтэй орон нутгийн оюутан залуусыг дэмжиж хөтөлбөртэй хамтран ажиллаж ирсэн.
Мөн Менторшип хөтөлбөртөө нийт 134 оюутан залуусыг элсүүлж, ажлын байранд гарахад бэлтгэсэн. Жил бүр Менторшип хөтөлбөрийн хүрээнд болон сурлагын өндөр амжилт үзүүлсэн орон нутгийн оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлдэг. 2022 онд Дундговь аймгийн 15 оюутан залууст сургалтын дэмжлэг үзүүллээ.

Солонгосын "Имарт Инк" компани нь Монголын оюутан, залуусын гадаад хэлний боловсролыг дэмжих, сурч боловсроход дэмжлэг үзүүлэх үүднээс Гадаад хэлний орчин үеийн лабораторийг МУИС-ийн хичээлийн II байрны 4 давхар 466 тоотод нээлээ. 20 ширхэг иж бүрэн, суурин компьютерыг холбогдох хэрэгслийн хамтаар МУИС-ийн удирдлагууд болон оюутан залуусыг 2016 оны 7 дугаар сард хүлээлгэн өглөө.



Нийгэм

Хөдөө орон нутгаас нийслэл хотод эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүдийн гэр бүлд зориулсан "Хавдартай өвчтөнүүдэд зориулсан байр" төслийг дэмжин өрөөний дотоод засал, тохижилтыг хийсэн.



Дээрхийн гэгээнтэн, XIV Далай ламын мэлмий гийсний 84 насны ойн өдөр амаржсан эх, хүүхэд болон амаржих гэж буй эмэгтэйчүүдэд гарын бэлэг гардуулсан.

Зорилтот гэр бүлийг дэмжих, хүнд өвчтэй хүүхдүүд мөн хүүхдийн эмнэлгүүдийн кабинетийг тохижуулах зорилгоор зохион байгуулагдсан “Ирээдүй өөд итгэл хайрлая” тоглолтыг ивээн тэтгэсэн.

Хөл хорионд байгаа ард иргэдэд хүнсний тусламж үзүүлэх “EMART FOOD BANK” аяныг санаачлан Митчелл сантай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эхлүүлсэн билээ. Тус аян олны сайшаалыг хүлээж, маш олон байгууллага хувь хүмүүс сэтгэл гарган хүчээ нэгтгэн ажиллаж “Монголчууд эвтэй байхдаа хүчтэй” гэдгээ батлан харуулсан.

“Скай Хайпермаркет” ХХК-ийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид-19 цар тахлын яг голомтод, халдварын эрсдэл өндөртэй нөхцөлд, өвчтөнтэй нүүр тулан ажиллаж буй эмч, сувилагч нарт шаардлагатай хэрэгсэл бүхий аранзыг бэлтгэн хүргүүллээ.

Имарт нь нээлтээ хийсэн цагаас эхлэн үндэсний үйлдвэрлэл эрхлэгч, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчидтэй бүх талын хамтын ажиллагааг бий болон ажиллахыг зорьдог билээ. Энэ зорилгын хүрээнд 2022 онд Имартын хамт олон Сэлэнгэ аймгийн Баянгол сумд байрлах “Бялхам Ивээл” ХХК-ийн хүлэмжийн аж ахуйн талбайн зэрлэг ургамлыг хадаж цэвэрлэсэн бөгөөд мөн тус аймгийн Мандал суманд байрлах “Эрдэнэ Энх” ХХК-ийн эрт ургацын 10 гаруй тонн төмс хураав.

Бүх нийтийн бэлэн байдлын үед ард иргэдээ хүнсээр тасралтгүй хангах үүргээ ухамсарлан, хичээнгүйлэн ажиллаж буй Имартын нийт 800 гаруй ажилтнаа урамшуулан, хүнсний бараа бүтээгдэхүүн олгосон талаар мэдээлж байсан билээ. Ажилтнууд ч үүнд маш их талархаж байгаагаа, компаниараа бахархаж буйгаа сошиал сувгаар дамжуулан давлагаалан илэрхийлж байсан юм. “Скай Хайпермаркет” ХХК-ийн зарим ажилтан компаниас өгсөн хүнсний хангамжийг өөртөө авалгүй, тусламж илүү хэрэгтэй байгаа хүмүүст хандивлах саналыг гаргасан бөгөөд компанийн зүгээс уг санаачлагыг дэмжин амьжиргааны түвшин доогуур, олон хүүхэдтэй өрх толгойлсон ганц бие эмэгтэйчүүд, өндөр настан гэх мэт нийт 200 өрхөд хүнсний бараа бүтээгдэхүүн хандивласан байна.

Өв Соёл: Түүхийн үнэт өв болсон хуучны дуугаа хойч үедээ өвлүүлэн үлдээх, хадгалах зорилгоор зохион байгуулдаг “Үл тасрах аялгуу төсөл”-ийн 2019 оны улсын уралдаан “Хүрэн хаалгатай дэлгүүр” нэрийн дор худалдааны ажилтан, худалдагч нарын дунд зохион байгуулагдсан бөгөөд тус нэвтрүүлгийн ивээн тэтгэгчээр ажилласан.

Тусгай хэрэгцээт иргэд - “Ability expo-2023”

Тогтвортой хөгжил, эрх тэгш оролцоо, олон талт байдлыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих, тэдгээрийн тулгамдсан асуудлыг хэлэлцэн, хамтын шийдэл олоход дэм болох үүднээс 2 дахь жилдээ зохиогдож буй “Ability Expo-2023”-г ивээн тэтгэн оролцлоо.

Хүүхэд - Go Blue

“Дэлхийн Хүүхдийн Өдөр”-т нэгдэж өнөөгийн нийгэмд амин чухалд тооцогдох хүүхдийн эрхийн төлөө дуу хоолойгоо илэрхийлэн оролцлоо.

Өндөр настан - Silver age

Тэтгэврийн насны иргэдийн оюуны болоод амьдралын арга барил, бие бялдрын нөөцийг зөв хуваарилж чадах юм бол ажлын нөөц байгаа юм байна шүү гэдгийг харуулах зорилгоор хийгдэж буй “Шинэ ажилтан” зорилтот нэвтрүүлгийг дэмжин ажилласан. Уг нэвтрүүлэг нь манай компанийн өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудыг шинээр болон үргэлжлүүлэн ажлын байраар хангах бодлоготой явц цав тохирч байгаа юм.



3.2.3-3 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ–ОЛИМПИЗМЫГ ДЭМЖИГЧ

Спорт урлаг

Монголын тусгай олимпын хороог дэмжин ажиллаж, АНЭУ-ын Абу-Дабид хотод зохиогдсон дэлхийн тусгай олимпод Монгол Улсаа төлөөлөн оролцсон тамирчид, дасгалжуулагч, арын албаны нийт 50 хүнд хувцас хэрэглэл гардуулсан.

ОУХМ Д.Бандийн нэрэмжит бага насны боксчдын "ОЛИМПЫН ГАРАА–40 ЖИЛ" тэмцээнд оролцсон нийт тамирчин, арын албаныхан болох нийт 500 хүнд амжилт хүсэж бэлэг гардууллаа.

Олимпизмыг дэмжигч байгууллагын хувьд залуу тамирчдыг дэмжин ивээн тэтгэн ажиллав. Үүнд:

- "Өсвөрийн улсын аварга 2017" тэмцээн;
- "Олимпын таеквондогийн Өсвөр үе, Монгол Улсын Аварга" шалгаруулах тэмцээн;
- "Баян-Адарга 2017" бага олимпын наадам;

"Бөртэ Чоно 2017" ёслолын ажиллагаанаас гадна Индонези улсын Жакарта болон Палембан хотуудад зохион байгуулагдсан Азийн XVIII наадмын Ерөнхий ивээн тэтгэгчээр ажилласан.

MYOX-ны түнш байгууллагаар ажиллан "Гэр" төслийг дэмжин ажиллав. Тус төсөл нь "Токио-2020" олимпын наадмын үеэр Монгол орны тухай мэдээллийг Олон улсын баг тамирчдад өгөхийн зэрэгцээ өөрийн орны тамирчдын мэдээллийг Монголчуудаа цаг алдалгүй хүргэж байлаа. "Скай Хайпермаркет" ХХК буюу Имартын удирдлагууд болон Монголын үндэсний олимпын хорооны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Олон улсын олимпын хороо /ОУОХ/-ны гишүүн Б.Баттүшиг нар "Токио-2020" зуны паралимпын XVI наадмын хүндийн өргөлтийн тэмцээний 107 кг-ын жинд бяр чадлаа амжилттай сорьж, алтан медаль хүртсэн тамирчин Э.Содномпилжээ, дасгалжуулагч багш Д.Баттулга нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, Имартын зүгээс паралимпын аварга Э.Содномпилжээд 50,000,000 төгрөг, дасгалжуулагч багш Д.Баттулгад 10,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал гардуулав.

3.2.3-3 ТОГТВОРТОЙ НИЙГЭМ –ОЛИМПИЗМЫГ ДЭМЖИГЧ

“Скай Хайпермаркет” буюу Имарт хайпермаркет нь “Монголын Үндэсний Олимпын Хороо”-той “Албан ёсны мөнгөн түнш” байгууллагаар хоёр жилийн хугацаатай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Хөдөл, Тогло, Хөгж

Дэлхийн хэмжээнд 330 гаруй салбарыг ажиллуулж байгаа БНСУ-ын Плэйтайм групптэй хамтран олимпизмыг дэмжих зорилгоор 2 дах салбарыг Баянгол салбарт нээлээ.

“Улаанбаатар 2023” Зүүн Азийн залуучуудын наадмын ивээн тэтгэгч

Азийн цомын аварга шалгаруулах уран сайхны гимнастикийн тэмцээний Ерөнхий ивээн тэтгэгч

Өсвөрийн гольфийн Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээний Ерөнхий ивээн тэтгэгч

3.3 ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь “хариуцлагатай засаглал бол амжилтын гол цөм” гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Монголын жижиглэнгийн худалдааны салбарт бий болгосон “Имарт Монгол” нэр хүнд бол зөвхөн санхүүгийн ололт амжилтаар тогтохгүй, бидний баримталдаг ёс суртахууны зарчим, ил тод, хариуцлагатай байдлын төлөөх тууштай үйл ажиллагааны үр дүн юм. Энэхүү БОНЗ-ын тайлан нь бидний тогтвортой хөгжил болон шударга, ёс зүйтэй бизнесийг тууштай эрхэлж буйг илэрхийлнэ.

Хариуцлагатай засаглалын зарчмууд нь манай байгууллагын үндэс суурийг бүрдүүлдэг оролцогч талуудын үнэ цэнийг бий болгох бидний хүсэл зорилго, үүрэг даалгаврын салшгүй хэсэг юм.

Бидний засаглалд хандах хандлага нь сайн засаглалыг компанийн үйл ажиллагааны бүхий л шатанд нэвтрүүлж, хэвшүүлснээр тогтвортой хөгжинө гэдэгт оршдог.

Бид ёс зүйт засаглалыг хэвшүүлэх, сайн засаглалын аялалдаа бүх оролцогч талуудтайгаа идэвхтэй хамтран ажиллахыг хичээдэг. Тэдэнтэй нээлттэй яриа хэлэлцээ, хариуцлагын орчинг бий болгосноор бид харилцан амжилтад хүрэх, хамтын ажиллагаагаа бэхжүүлсээр байна.

Тогтвортой байдлын төлөөх бидний амлалт нь ёс суртахууны үндсэн ойлголтоос эхлээд байгаль орчны ул мөрийг багасгах хүчин чармайлт хүртэлх компанийн үйл ажиллагааны бүх талбарт хамаатай. Хариуцлагатай засаглал нь ёс суртахууны зайлшгүй шаардлага төдийгүй байнга хувьсан өөрчлөгдөж буй жижиглэнгийн худалдааны орчинд үнэ цэнийг бий болгох гол хөдөлгөгч хүч гэдэгт бид итгэдэг.

Бид ирээдүйд тулгарах сорилт, бэрхшээлийг даван туулахдаа ажилтнуудынхаа сайн сайхан байдлыг дэмжиж, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалж, нийгмийг бүхэлд нь сайжруулахад хувь нэмрээ оруулах засаглалын үйл ажиллагаанд тууштай зүтгэсээр байх болно.

МАНАЙ ЗОРИЛГО	2023 ОНЫ ЗОРИЛТ
Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, сайн засаглалын ёс зүйт удирдлагын тогтолцоогоор худалдааны салбарыг түүчээлэх	Компанийн нийгмийн хариуцлагын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

БИДНИЙ ХИЙСЭН АЖИЛ



Авилгын эсрэг, ёс зүйт шударга менежментийг дэмжин, түгээн дэлгэрүүлэх

Мэдээлэлийн ил тод байдал

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хяналтын тогтолцоо

3.3.1 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн авлигын эсрэг, нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн ёс зүйг эрхэмлэн, ил тод шударга бизнесийг эрхлэн явуулахаа амлаж, хэрэгжүүлэн ажилласаар байна.
Тус ажлын хүрээнд дараах 4 үнэт зүйлээ чиглэл болгон мэдээллээ ил тод байлгаж, нээлттэй байдлаар ажиллаж байна.

Хэрэглэгчид:

- Хэрэглэгчдэд цаг алдалгүй мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлт, гомдлыг хүлээн авахаар 6 оператортой, өдөрт 300~400 хэрэглэгчийн гомдлыг хүлээн авах хүчин чадалтай дуудлагын төв үйл ажиллагаагаа явуулж байна.
- Мөн хэрэглэгчдэд илүү ойр байх үүднээс Сошиал сувгуудын чатботыг ашиглаж байна.
- Салбар дэлгүүр бүрт Хэрэглэгчийн үйлчилгээний төвүүдийг ажиллуулан хэрэглэгчдэд мэдээлэл хүргэж асуулт, санал хүсэлтэд хариу өгч ажиллаж байна.

Харилцагчид:

Өртөө систем: Хамтрагч талуудын хооронд мэдээллийг цахим хэлбэрээр (үнийн өөрчлөлтийн мэдээлэл, шинэ бараа, захиалга, буцаалт, борлуулалт, нөөцийн мэдээлэл, төлбөр тооцооны баримт бичиг гэх мэт) солилцох программ.

Зорилго: Талуудын хамтын ажиллагааг сайжруулах, цаг хугацаа хэмнэх, ажиллагааг хөнгөвчлөх, мэдээлэл солилцоог сайжруулах.

Ач холбогдол: Өнөөгийн бизнесийн хөгжилд харилцагчтайгаа нягт уялдаа холбоотой, байнгын харилцаатай байж, тэдний санал гомдлыг сонсон, хамтын ажиллагаагаа байнга сайжруулах нь бизнесээ өргөжүүлэхэд чухал юм.

Харилцагчаас санал хүсэлт гомдлыг хүлээн авахаар 7611-0101 дугаарыг мөн ажиллуулж байна.

Ажилтнууд:

Ажилтны өөрийн цалин, авч байсан шагнал, компаниас олгодог хөнгөлөлттэй худалдан авалтын дүн, сарын гүйцэтгэлийн үнэлгээний хувь зэрэг мэдээллийг Mobile app ашиглан ажилтнууддаа хүргэдэг бөгөөд эргээд ажилтнуудаас өргөдөл, санал, гомдол, хүсэлт /чөлөө, ээлжийн амралт/ зэрэг мэдээллийг тус Mobile app-ийг ашиглан хүлээн авч шийдвэрлэдэг.

Жилд нийт 1512 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. Ажилтан өөрөө Хүний нөөцийн нэгдсэн системд хувийн мэдээллийг шинэчлэх, өөрийн албан тушаалд хамааралтай компанийн 180 гаруй дүрэм, журамтай танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигчид:

“Скай Хайпермаркет” ХХК-ийн хувьцаа эзэмшигч, БНСУ-ын “Имарт Инк” компанийн томилон ажиллуулдаг төлөөлөгч нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааны болон санхүүгийн программ, холбогдох мэдээлэлд Гүйцэтгэх захиралтай адил эрхтэйгээр нэвтэрч, хувьцаа эзэмшигч “Имарт Инк” компанийг мэдээллээр тогтмол хангадаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг улирал бүр тогтмол зохион байгуулж, хурлаар хэлэлцүүлэх асуудлын судалгаа, холбогдох материал, гэрээг англи, монгол хэлээр бэлтгэж, ТУЗ-ийн гишүүдэд хурлын өмнө хүргүүлдэг бөгөөд хувьцаа эзэмшигчид өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүдээрээ дамжуулан компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол авдаг.

3.3.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

"Скай Хайпермаркет" ХХК-ийн нийт хувьцааны 90 хувийг "Алтай холдинг" ХХК-ийн охин компани болох "Скай Трейдинг" ХХК, 10 хувийг БНСУ-ын "Имарт Инк" компани эзэмшдэг. 2014 онд компанийг үүсгэн байгуулахдаа "Алтай холдинг" ХХК болон "Имарт Инк" компаниуд Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу "Скай Хайпермаркет" ХХК-ийн дүрэм батлагдсан.

Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд "Скай Хайпермаркет" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын бүрэн эрх, хурлын тогтоол хүчин төгөлдөр болох журам, Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг зэргийг нарийн тусгаж өгсөн.

Уг гэрээний гол зохицуулалт нь жижиг хувьцаа эзэмшигч болох БНСУ-ын "Имарт Инк" компани "Скай Хайпермаркет" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн шийдвэр гаргалтад оролцох оролцоог хангах, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар нэг хязгаарлалтгүйгээр тогтмол авах, компанийн үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

"Имарт Инк" компани нь хамтарсан компанийн 10 хувийн хувьцааг эзэмшдэг хэдий ч Компанийн тухай хуулийн 62.1 дэх хэсэгт заасан зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас гадна "Скай Хайпермаркет" ХХК-ийн зорилго, бизнесийн үйл ажиллагааг өөрчлөх, компанийн хувьцаа болон их хэмжээний хөрөнгийг худалдах, ногдол ашиг хуваарилалт, хувьцаа эзэмшигчид хамтарсан компанид эзэмшиж буй хувьцаагаа гуравдагч этгээдэд шилжүүлэх, компани тогтоосон хэмжээнээс дээш хэмжээний зээл авах зэрэг компанийн бизнесийн чухал шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэхээр заасан байдаг. Мөн хурлаар шийдвэр гаргуулах бүрд хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухай бүр зарлаж хуралдуулдаг.

Үүнээс гадна "Имарт Инк" компани нь "Скай Хайпермаркет" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 4 гишүүний нэгийг томилдог бөгөөд бизнес төлөвлөгөө батлах, газрын захирлуудыг томилох, тогтоосон хэмжээнээс дээш үнийн дүнтэй зээл авах, компанийн эд хөрөнгийг барьцаалах, компани батлан даалт гаргах, компани хувьцаа эзэмшигчтэй хамаарал бүхий этгээдтэй хийгдэх сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх, компанийн аудиторыг томилох зэрэг компанийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд чухал шийдвэрүүдийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэхээр компанийн дүрэмд заасан.

Мөн компанийн дүрэмд заасан зохицуулалтыг Хувьцаа эзэмшигчид мөрдөөгүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагын механизмыг дээр дурдсан "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-нд тодорхой зааж өгсөн учир Хувьцаа эзэмшигчид тус гэрээ болон компанийн дүрмийг чанд мөрдөж ажилладаг.

Энэ нь хамтарсан компанийн бизнесийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий гол шийдвэрүүдийг Хувьцаа эзэмшигчид харилцан зөвшилцөж шийдвэрлэх, жижиг Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудын засаглалд сайн жишиг болохуйц компанийн засаглалын механизмыг "Скай Хайпермаркет" ХХК бүрдүүлсэн болно.

"Скай Хайпермаркет" ХХК-ийн дүрэмд заасны дагуу "Имарт Инк" компани нь өөрийн төлөөлөгчөө "Скай Хайпермаркет" ХХК-нд Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэгтэйгээр тогтмол ажиллуулж компанийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг нь жижиг Хувьцаа эзэмшигч Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-өөр дамжуулан компанийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн.

4.1 ГИШҮҮНЧЛЭЛ БОЛОН ШАГНАЛ

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Entrepreneur	Онцлох хөрөнгө оруулагч	2017
Entrepreneur	Дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжигч	2018
Entrepreneur	Худалдааны салбарын онцлох энтрепренер	2019
Entrepreneur	Сайн засаглалыг хэрэгжүүлэгч	2021
Entrepreneur	Ази, Номхон далайн орнуудын ХАҮТ-уудын Нэгдсэн Холбооны “Silver Mercury” шагнал	2023
Топ 100 ААН	98 дугаар байр	2016
	72 дугаар байр	2017
	63 дугаар байр	2018
	40 дүгээр байр	2020
	31 дүгээр байр	2021
	23 дугаар байр	2023
Олимпын Хороо	“Бөртэ Чоно” шилдэг ивээн тэтгэгч	2023
Голомт	Топ 10 картаар үйлчлүүлэгч байгууллага	2016
Mongolian property awards	Шилдэг худалдааны төв	2016
Bloomberg	Bloomberg awards	2022

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Management forum	Шилдэг CEO	2022
Анунгоо /20 жилийн ой/	Топ харилцагч	2019
Худалдааны салбарын шагнал	“Мөнгөн богц”	2018
Талархалын батламж	Нийслэлийн засаг дарга, Улаанбаатар хотын захирагч Сумъяабазар	2022
Худалдааны салбарын шагнал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй дэд бүтэц, орчныг бүрдүүлсэн байгууллага	2017
Хөдөлмөр нийгэм хамгааллын аям	Хүүхэд гэр бүлд ээлтэй ААНБ	2021
ХБХХЕГ	Хөгжлийн бэлхшээлтэй иргэдэд ээлтэй ААНБ	2021
“HR Club” ТББ	Манлай хүний нөөцийн төсөл	2019
НЗДТГ, НЭМНДГ	Нийслэлийн оны шилдэг шимтгэл төлөгч ажил олгогч байгууллага	2017
ХҮДС-ийн Талархалын батламж	Уншлагын танхим иж бүрэн тохижуулж өгсөнд талархал	2019
Үндэсний бизнес хөгжлийн нийгэмлэг	Монгол Чанар	2017
	Оны хамгийн өндөр борлуулалтын өсөлттэй харилцагч	2018
Хүндэт харилцагч	Оны шилдэг харилцагч	2017, 2018
	Шилдэг барилга байгууламж шалгаруулалт	2016
	Шилдэг худалдааны төв	2016

4.1 ГИШҮҮН БОЛОН “САНАМЖ БИЧИГ” БАЙГУУЛСАН БАЙГУУЛЛАГУУД

БАЙГУУЛЛАГЫН НЭР
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Монголын Үндэсний Олимпын Хороо
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Нийслэлийн Онцгой байдлын газар
Монголын Таеквондогийн Холбоо
Монгол Улсын Их Сургууль
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль
Голомт банк ХК
Худалдаа хөгжлийн банк ХК
“Бид Чадна” ТББ - хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний портал
Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв

4.2 НҮБ-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

Ангилал	НҮБ-ийн ТХЗорилго	Имартын хувь нэмэр оруулж буй хамааралтай зорилтууд
Зорилго 1	Ядуурлыг устгах - Ядуурлын бүх хэлбэрийн арилгах	Орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгмийн хувь нэмэр: Итгэл, найдвараа хуваалцъя төсөл, Дэм дэмэндаа аян, Food bank аян * Хүүхдэд чиглэсэн нийгмийн хувь нэмэр: Асрамжийн газрын бяцхан хүүхдүүдэд бэлэг, хандив
Зорилго 2	Өлсгөлөнг зогсоох - Өлсгөлөнг зогсоож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээлийн баталгааг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих	**Орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгмийн хувь нэмэр:** Сар шинийн баярыг тохиолдуулан туслах дэмжих үр хүүхэдгүй ганц бие өндөр настнуудад сар шинийн бууз хийж бэлэглэх сэтгэлийг аян, Дэм дэмэндээ аян 2221 өрхөд хүнсний багц
Зорилго 3	Эрүүл мэнд, Мэнд оршихуй - Бүх насныханд зориулсан эрүүл амьдралын баталгаа, мэнд оршихуйг дэмжихүй	**Эрүүл мэнд, аюулгүй байдал:** Монгол хүн та 100 наслаг хөтөлбөр **Аз жаргалтай ажилтан хөтөлбөр:** эрүүл мэнд, санхүү, сэтгэлзүйн, гэр бүлийн эрүүл мэндийн цогц хөтөлбөр
Зорилго 4	Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих	Талант (авъяасын) менежмент: Ур чадварын 5 багц сургалт, Export to Korea, Хөх Шошго хөтөлбөр Оюутан залуусын сурах тав тухтай орчинг бүрдүүлэх номын сан тохижуулах, гадаад хэлний танхим, Сургалтын төлбөрийн дэмжлэг хөтөлбөр Хүүхдэд зориулсан нийгмийн хувь нэмэр: Өсвөрийн тамирчдын Олимпизмыг дэмжигч хөтөлбөр
Зорилго 5	Жендерийн тэгш байдлыг хангах, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхижуулах	**Хөдөлмөр-менежментийн хамтын ажиллагаа ба хүний эрхийн менежмент:** Хүний эрхийн сургалт, ажил, амьдралын тэнцвэрт байдал Эмэгтэй ажилтны харьцаа 70 хувь, эмэгтэй ажилтны дундаж ажилласан хугацаа 10 жил байна
Зорилго 6	Баталгаат ундны ус, Ариун цэврийн байгууламжаар хангах - Хүн бүрийг тэгш хүртээмжтэй баталгаат ус, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах	**Тойрог эдийн засгийг бий болгох:** Ариун цэврийн өрөөнд зөвхөн ухаалаг мэдрэгчтэй цорго суурилуулах, Хүнсний хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах санаачлага **Үнэ цэнийн ойлголттой ухаалаг хэрэглээг дэмжих:** 5 өнгө хөтөлбөр, Байгаль хамгаалагч Цоохор ирвэс дижитал зургийн уралдаан
Зорилго 7	Боломжийн Цэвэр Эрчим хүч - Хүн бүрийг боломжийн, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүч хэрэглэх боломжоор хангах	**Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ:** Эрчим хүчний хэмнэлттэй шинэ салбар дэлгүүр, нарны эрчим хүч ашиглах туршилтыг эхлүүлэв. Онлайн худалдааны түгээлтэд цахилгаан автомашин, мопед ашиглаж эхлэв.
Зорилго 8	Зохистой хөдөлмөр, Эдийн засгийн өсөлт - Хүн бүрд тогтвортой, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлт, бүрэн, үйлдвэрлэлийн бүх нийтийн хөдөлмөр эрхлэлт, зохистой хөдөлмөр	**2016 онд нээгдснээс хойш нийт 1400 ажлын байр** * Цалинтай ээж хөтөлбөр * Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр * Цалинтай оюутан ажлын байр * Өндөр настнуудад зориулсан ажлын байр

4.2 НҮБ-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

Ангилал	НҮБ-ийн ТХЗорилго	Имартын хувь нэмэр оруулж буй хамааралтай зорилтууд
Зорилго 9	Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх - Уян хатан дэд бүтцийг байгуулж, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг дэмжиж, инновацыг хөгжүүлэх	Гидропоник төсөл
Зорилго 10	Тэгш бус байдлыг бууруулах - Улс хоорондын болон дотоодын тэгш бус байдлыг бууруулах	**Хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж:** "Ирээдүй өөд итгэл хайрлая" тоглолтын ивээн тэтгэгч, Хүүхдийн номын сан, **Орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгмийн хувь нэмэр:** Итгэл найдвараа хуваалцъя төсөл, " Хавдартай өвчтнүүдэд зориулсан байр төслийг дэмжигч, Эх хүүхдийг баярлуулах ажил, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагааг хурлын байраар хангагч, Ability Expo- 2023 үйл ажиллагааны ивээн тэтгэгч
Зорилго 11	Тогтвортой Хот, Иргэдийн нийгэм - Бүгдийг хамарсан, аюулгүй, найдвартай, тогтвортой хот, суурингуудыг бий болгох	**Аюулгүй байдлыг хангах:** Онцгой байдлын албаны албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах багаж хэрэгслийн сэтгэлийн бэлэг, ХАБЭА-ийн мэдлэг олгох сургалт, Анхан шатны тусламж үзүүлэх сургалт, Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургалт **Хүүхдэд зориулсан нийгмийн хувь нэмэр:** Замын хөдөлгөөн ба Хүүхэд аюулгүйн бүс аян, 5 өнгө хөтөлбөр, Номын сан, Playtime тоглоомын төвтэй хамтран хамгийн доод үнийн бодлого
Зорилго 12	Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл - Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтцийг бүрдүүлэх	**Тойрог эдийн засгийг бий болгох:** Хүнсний бордоо, цаасны хог хаягдлыг боловсруулан онлайн хүргэлтийн савалгаанд ашиглах санаачилга **Тогтвортой бүтээгдэхүүний түгээлт:** Гидропоник төсөл, Органик бүтээгдэхүүний тасаг
Зорилго 13	Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар яаралтай арга хэмжээ авах	**Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ:** Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R хөтөлбөр
Зорилго 15	Дэлхийн экосистемийг хамгаалах, сэргээх болон тогтвортой хэрэглээг дэмжих, ойн зохицуулалтыг тогтворжуулах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоон, эргүүлэн сэргээх, биологийн төрөл зүйлийн усталтыг зогсоох	**Ирээдүйд байгалиа үлдээе:** Тэрбум мод, Өрх бүр нэг мод, Хог биш мод тарья, Ажилтны хүүхдүүдэд модны суулгац бэлэглэн тарих хөтөлбөрүүд, Цаасгүй оффис, **Байгаль хамгаалагч:** эко тор, олон удаа ашиглах аяга хөтөлбөрүүд
Зорилго 16	Тогтвортой хөгжлийн төлөөх тайван, бүгдийг хамарсан нийгмийг дэмжих, шударга ёсыг бүгдэд хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүгдийг хамарсан тогтолцоог бий болгох	**Хүний эрхийн менежмент:** Хүний эрхийг бизнесийн үйл ажиллагаанд хүндэтгэн дээдлэе уриан доор байгууллагын тогтмол ашиглагддаг гэрээнүүдэд хүний эрхийн заалтыг тусгах ажил
Зорилго 17	Хэрэгжилтийн арга замыг бэхжүүлэх болон тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагааг сэргээх	**БТБС:** Нийслэлийн Захирагчийн ажлын алба болон Азийн хөгжлийн банкны Хүнсний хаягдалаар бордоо хийх төсөл, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Мянганы Хөгжлийн туурвил " Ability Expo 2023", UNICEF "World Children's Day",

emart

Монгол хүн Та 100 наслаг...